



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН  
ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР,  
ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ



Төслийн дугаар: 50091-002  
Зээлийн дугаар L3594-MON  
2021 оны 03 сар

## **МОНГОЛ УЛС: ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙН ҮЕД БОЛОВСРОЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ТӨСӨЛ**

**Гадаадад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн багш  
мэргэжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн судалгааны тайлан  
(Гэрээ №02)**

Төслийн гүйцэтгэгч болон хэрэгжүүлэгч байгууллага Боловсрол, шинжлэх ухааны яамны захиалгаар судалгаа хийх үйлчилгээ үзүүлэв.

Ажлын хэсгийн тайлан нь АХБ болон Монгол Улсын байр суурь биш бөгөөд АХБ, МУЗГ нь тайлангийн агуулгын хүрээнд ямар нэгэн хариуцлага хүлээхгүй болно.

Улаанбаатар хот



## БАГШ БЭЛТГЭХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

### АГУУЛГА

Удиртгал .....	4
НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ХАРЬЦУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ .....	5
1.1. БМИҮЗ, МУБИС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуурын харьцуулалт, үр дүн .....	5
1.2. БМИҮЗ, ASIIN-ий хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үнэлгээний шалгуурын харьцуулалт, үр дүн .....	7
ХОЁР. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ .....	13
2.1. Ерөнхий шинжилгээ .....	13
2.2. Хичээлийн иж бүрдлийн шинжилгээ .....	14
2.3. Хичээлийн чанар, багшийн арга зүй .....	15
2.4. Хандлага, сэтгэл ханамж .....	16
2.5. Нэгдсэн үнэлгээ .....	17
ГУРАВ. ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ .....	19
3.1. Ерөнхий шинжилгээ, үр дүн, дүгнэлт .....	19
3.2. Хичээлийн хөтөлбөрийн шинжилгээ, үр дүн, дүгнэлт .....	26
3.3. Хичээлийн чанар, багшийн арга зүйд хийсэн шинжилгээ, үр дүн, дүгнэлт .....	34
3.4. Хандлага, сэтгэл ханамжийн судалгаа, үр дүн, дүгнэлт .....	47
3.5. Нэгдсэн үнэлгээний сорил, үр дүн, дүгнэлт .....	59
ХАВСРАЛТ .....	69

## Удиртгал

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс бүх шатны хөтөлбөрүүдэд магадлан итгэмжлэл хийдэг. Өнөөгийн байдлаар Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд 2004 оноос хойш нийт 448 хөтөлбөр магадлан итгэмжлэгдэж, 225 хөтөлбөрийн хүчинтэй хугацаа дуусаж, 208 хөтөлбөрийн магадлан итгэмжлэл хүчинтэй байна. Үүнээс багш бэлтгэх хөтөлбөрүүдийн хувьд 6 их сургуулийн 45 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэн байна. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь сургууль бүрээс тухайн хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар нотлох баримтуудыг тодруулсан өөрийн үнэлгээний тайлан бичүүлж, хөндлөнгийн комисс бүрдүүлж газар дээр нь очиж, оюутан, багш, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөлтэй уулзаж, дүгнэлт өгдөг билээ. Энэхүү үнэлгээ нь их сургуулиудын өөрийн үнэлгээнд суурилж хийгддэг, хөтөлбөрийн баримт бичгүүдэд шинжилгээ хийж, ярилцлага, сэтгэл ханамжийн судалгаа, сэтгэгдэлд суурилан дүгнэлт гаргаж, сайжруулах зүйлүүдийг мөн санал болгодгоороо онцлог билээ.

МУБИС-ийн хувьд 2014 оноос эхлэн шинэчлэн хэрэгжүүлж буй багш бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны арга зүй боловсруулж, 2017-2019 онд тэнхим, бүрэлдэхүүний сургууль бүр өөрийн хэрэгжүүлж буй багш бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлж, тайлагнасан. Уг ерөнхий арга зүй нь БМИҮЗ-ийн ерөнхий шалгуур шаардлагыг нарийвчилж, үндсэн 7 бүтэцтэй, тухайн бүтэц, бүрэлдэхүүн тус бүрд нотолгоог хэрхэн боловсруулахыг тодруулснаараа онцлог байна.

Бид энэхүү төслийн хүрээнд гадаад, дотоодод магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуур, удирдамжийг боловсруулахдаа дээрх үнэлгээний арга зүй болон магадлан итгэмжлэлийн тайланд тусгагдсан үзүүлэлтүүдийг харьцуулах, тусгагддаггүй үзүүлэлтүүдийг тусган, баримт бичиг болон ажиглалт, ярилцлагын аргаар илрүүлэхэд голлон анхаарсан болно.

Бид магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийн талаарх ерөнхий мэдээлэл, хичээлийн хөтөлбөр, хичээл ажиглалт гэсэн байдлаар баримт бичиг, нөхцөл байдлын шинжилгээ хийхээс гадна бодит хичээлд ажиглалт хийх, багш, оюутантай ярилцлага хийх, оюутнаас сэтгэл ханамжийн судалгаа, мөн 3 болон 4 дүгээр ангийн оюутнаас багш боловсролын мэдлэг шалгах сорил авч шинжлэх зэрэг үйл ажиллагааг төлөвлөн судалгаандаа хэрэгжүүллээ.

Судалгаанд дотоодод магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэх хөтөлбөрүүдийн талаар ерөнхий мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсэн. Мөн МУБИС, Отгонтэнгэр их сургууль, Дорнод их сургууль, Ховд их сургуулийн хичээл ажиглалт, багш оюутантай ярилцаж үр дүнг нэгтгэсэн. Сорилд багш бэлтгэх хөтөлбөрийг хэрэгжүүлж буй сургуулийн оюутнуудын төлөөллийг хамруулсан байна.

Эдгээр өгөгдлүүдийг нэгтгэн дүгнэж, хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны арга зүй болон хэрэгжилтийн үр дүнг энэхүү тайланд тусган эмхэтгэсэн болно.

## **НЭГ. ХӨТӨЛБӨРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙН ХАРЬЦУУЛАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ**

Энэ хэсэгт БМИҮЗ-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, МУБИС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгааны шалгуур, ASIIN байгууллагын олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур зэргийг харьцуулсан үр дүн, дүгнэлтийг оруулав. Энэхүү үр дүнд үндэслэн магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн үнэлгээний ерөнхий арга зүйг боловсруулна.

### **1.1. БМИҮЗ, МУБИС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуурын харьцуулалт, үр дүн**

БМИҮЗ-ийн бакалаврын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагыг дараах агуулгатай боловсруулжээ. Үүнд:

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

- 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага
- 1.2. Хөтөлбөрийн зорилго
- 1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа

- 2.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл
- 2.2. Сургалтын арга зүй
- 2.3. Суралцагчийн үнэлгээ

Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

- 3.1. Сургалтын орчин
- 3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн
- 3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

- 4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа
- 4.2. Хамтын үйл ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ
- 4.3. Санхүүжилт
- 4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт
- 4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйл ажиллагаа

- 5.1. Суралцагч сонгох, элсүүлэх
- 5.2. Зөвлөн туслах үйлчилгээ
- 5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо
- 5.4. Суралцагчийн шилжилт хөдөлгөөн
- 5.5. Төгсөлтийн баримт бичиг

Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа

- 6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого
- 6.2. Багшийн хөгжил
- 6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа
- 6.4. Багшийн үнэлгээ

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт

- 7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт
- 7.2. Хөтөлбөрийн үр дүн
- 7.3. Үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдөх

МУБИС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийн шалгуурын агуулгыг дор оруулав.

## 1.ХӨТӨЛБӨРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

- 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага
- 1.2. Хөтөлбөрийн зорилго
- 1.3. Хөтөлбөрийн үр дүн (PLO), хичээлийн үр дүн (CLO)-ийн хамаарал
- 1.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө
- 1.5. Элсэлт, элсэгчдийн чанар
- 1.6. Хөтөлбөрийн санхүүжүүлэлт

## 2.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

- 2.1. Сургалтын үйл ажиллагааны төлөвлөлт, зохион байгуулалт
- 2.2. Сургалтын агуулга, арга зүй, үнэлгээ
- 2.3. Сургалтын орчин
- 2.4. Хөтөлбөр хэрэгжүүлэх хүний нөөц
- 2.5. Харилцаа, хамтын ажиллагаа
- 2.6. Оюутны хөгжлийг дэмжих үйл ажиллагаа

## 3.ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

- 3.1. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт
- 3.2. Төгсөгчдийн чанар, ажил эрхлэлт
- 3.3. Төгсөгчидтэй хамтран ажиллах

## 4.ХӨТӨЛБӨРИЙН САЙЖРУУЛАЛТ

- 4.1. Хөтөлбөрийн төлөвлөлт
- 4.2. Хөтөлбөрийн хэрэгжилт
- 4.3. Хөтөлбөрийн үр дүн

БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх шалгуурыг МУБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгууртай харьцуулахад:

### Үнэлгээний бүтцийн хувьд:

БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх шалгуур	МУБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгуур
7 үндсэн шалгууртай, шалгуур тус бүр 3-5 (нийт 26) дэд шалгууртай ба тус бүрд задлан шинжлэх асуулт, илрэл нотолгоог тодорхой тусгаж өгсөн байна.	4 үндсэн шалгууртай, шалгуур тус бүр 3-6 (нийт 17) дэд шалгууртай ба тус бүрд үнэлгээний асуулт, үнэлгээний арга, хэрэгслийг тодорхой тусгаж өгсөн байна.

**Дүгнэлт:** МУБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгуур нь БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх 3 үндсэн шалгуураар бага байгаа боловч 25 дэд шалгуурыг багтаасан байна.

### Агуулгын хувьд:

1. МУБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгуур нь БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх шалгуурыг нэгтгэн багтаасан байна.

Тухайлбал,

- 1-р үндсэн шалгуур болох хөтөлбөрийн төлөвлөлтөд БМИҮЗ-ийн 1 шалгуур;

- 2-р үндсэн шалгуур болох хөтөлбөрийн хэрэгжилтэд БМИҮЗ-ийн 2, 5, 6 шалгуурууд;
- 3-р үндсэн шалгуур болох хөтөлбөрийн үр дүнд БМИҮЗ-ийн 3, 4, 7 шалгуурууд.
- 4-р үндсэн шалгуур болох хөтөлбөрийн сайжруулалтад 1-7-р шалгуурт гарсан асуудал, бэрхшээл түүнийг шийдэх саналуудыг тусгасан байна.

**Дүгнэлт:** МУБИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлэх шалгуурт Хөтөлбөр хэрэгжүүлэх хүний нөөцийн 2.4-т Багшийн ажлын ачаалал, үнэлгээ, Багш бус ажилтны хөгжил дэд шалгуур нэмэгдсэн байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтийг цогц байдлаар үнэлэхэд боломж хангагдсан байна. Харин хөтөлбөрийн үр дүн гэсэн 3-р үндсэн шалгуурт БМИҮЗ-ийн дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэх 5.5 Төгсөлтийн баримт бичиг гэсэн дэд шалгуур байхгүй байгаа нь төгсөлтийн баримт бичгийг олгох дүрэм журмын хэрэгжилтийг хянадаг, төгсөлтийн баримт бичгийн баяжилт, албажуулалт нь олон улсын жишигт нийцсэн эсэх талаар мэдээлэл дутуу байна.

## **1.2. БМИҮЗ, ASIIN-ий хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн үнэлгээний шалгуурын харьцуулалт, үр дүн**

МУБИС нь математик, байгалийн ухааны багш бэлтгэх 6 хөтөлбөр (математик, мэдээлэл зүй, хими, физик, биологи, газарзүйн багш)-өө ХБНГУ-д төвтэй Европын холбооны улсуудад хүлээн зөвшөөрөгддөг ASIIN байгууллагаар олон улсад амжилттай магадлан итгэмжлүүлсэн.

Иймд ASIIN болон БМИҮЗ-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгууруудыг харьцуулан шинжилсэн үр дүнг оруулж байна.

Судалгаанд хөтөлбөрийн олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллага болох ASIIN-ий бакалаврын хөтөлбөрт тавих ерөнхий шаардлагын шалгуур тус бүрийг БМИҮЗ-ээс баталсан сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлагатай харьцуулан ижил болон ялгаатай байдлыг илрүүлэх, онцлогийг тодруулах зорилго тавьж ажиллав. Харьцуулахдаа шалгуурын нийцэж буй байдал, шалгуур тус бүрийн нийцлийн хувийг илэрхийлсэн тоон шинжилгээ, шалгуурт заасан шаардлагын агуулгыг харьцуулсан чанарын шинжилгээг тус тус хийлээ. (Т.Ганбаатар, Д.Цэдэвсүрэн, Г.Батцэцэг, 2022).

ASIIN байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур (цаашид А шалгуур гэх) нь 6 бүлэг, 16 дэд, 54 нарийвчилсан шалгуураас бүрдэж байна. БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур, шаардлага (цаашид В шалгуур гэх) нь 7 бүлэг, 26 дэд шалгуураас бүрдсэн байна. Эдгээр шалгуурын бүлэгт хуваасан байдлыг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 1. А шалгуур*

	Бүлэг	Дэд шалгуур
1	Мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр: үзэл баримтлал, агуулга, хэрэгжүүлэх үйл явц	Мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн зорилго, сурах үр дүн Хөтөлбөрийн нэр Хөтөлбөр Элсэлтийн журам

2	Мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөр: бүтэц, аргагүй, хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Бүтэц, хичээлүүд Сургалтын ачаалал, кредит Заах аргагүй Дэмжлэг, туслалцаа
3	Шалгалт: үнэлгээний тогтолцоо, үзэл баримтлал (зарчмууд), зохион байгуулалт	
4	Нөөц, хэрэглэгдэхүүн	Багшлах боловсон хүчин Багшийн хөгжил Санхүүгийн нөөц, тоног төхөөрөмж
5	Баримт бичгүүд	Хичээлийн танилцуулга Диплом Дүрэм, журам
6	Чанарын баталгаажуулалт: чанарын үнэлгээ, хөгжил	

А шалгуурын бүлэг, бүтцээс харахад энэ шалгуур нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх процесст илүү төвлөрсөн, элсэлт болон хөтөлбөрийн зорилго буюу орц, явц буюу хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгалт, арга зүй, багшлах болон бусад хүн хүч, санхүүгийн нөөц, хэрэгжилтэд баримтлах дүрэм журам, гарц буюу төгсөлт, төгсөлтийн баримт бичиг, чанарын баталгаажуулалтын асуудлыг хамарсан онцлог бүхий байна. А шалгуур нь тухайн дэд шалгуур бүрийг үнэлэхэд чиглэсэн нарийвчилсан шалгууруудыг дотроо багтааснаараа онцлогтой ажээ. Нарийвчилсан шалгуур нь тодорхой, нэг шалгуур нь нэг л зүйлийг илрүүлэхэд чиглэсэн байна.

А болон В шалгуурыг харьцуулсан тоон судалгааны дүнг дараах хүснэгтэд харуулав.

*Хүснэгт 2 . А ба В шалгуурын харьцуулалт*

Харьцуулах үзүүлэлт	Харьцуулалт	Дүгнэлт
Бүлгийн тоо	А шалгуур 6, В шалгуур 7 бүлэгтэй.	Бүлгийн тоо ялгаатай бөгөөд ижил нэртэй нэг бүлэг нь Чанарын баталгаажуулалт байна.
Дэд бүлгийн тоо, нэршил	А шалгуур 16, В шалгуур 27 дэд бүлэгтэй байна. Үүнээс ижил нэршилтэй буюу давхацсан 11 бүлэг байна. А шалгуурт байгаа, В шалгуурт байхгүй дэд бүлгийн тоо 5 байна.	А шалгуур нь В шалгуурын зарим шалгуурыг нэгтгэсэн байдалтай байна. Жишээлбэл, хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, зорилго нь А шалгуурт 1, В шалгуурт 2 дэд бүлгээр нэрлэгдсэн байна. А шалгуурт дурдсан Хичээлтэй холбоотой “Бүтэц, хичээлүүд”, “Хичээлийн танилцуулга”, “сургалтын ачаалал, кредит” зэрэг дэд бүлгүүд В шалгуурт ороогүй байна.
Нарийвчилсан шалгуурын тоо, нийцэл	А шалгуурын 54 нарийвчилсан шалгуураас В шалгуурын дэд	В шалгуур нь хэт ерөнхий бичигдсэн бөгөөд нэг дэд шалгуурт А шалгуурынхад хэдэн нарийвчилсан



	шалгууртай нийцэж буй шалгуурын тоо 15 байна.	шалгуур зэрэг багтсан шинжтэй байна.
--	---	--------------------------------------

Тоон харьцуулалт хийхэд шууд дүгнэлт гаргахад төвөгтэй байсан тул шалгуурын агуулгыг тодруулж, чанарын шинжтэй харьцуулалт хийсэн зарим үр дүнг Хүснэгт 3-д авч үзлээ.

*Хүснэгт 3. Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилготой холбоо бүхий шалгуурын харьцуулалт*

А шалгуур	В шалгуур
<p><b>1.1 Мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн зорилго, сурах үр дүн</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрөөс гарах үр дүнг товч бөгөөд тодорхой бичнэ. Эдгээр нь үндэслэлтэй, хэн бүхэнд ойлгомжтой энгийн хэл найруулгатай, багш, оюутан, суралцагчид, ажилтнуудад танилцах боломжтой байна.</li> <li>Үндэсний хэмжээнд багшид тавьж буй шаардлагад нийцсэн байх</li> <li>Хэрэгжих боломжтой, бодит байх</li> <li>Байнга задлан шинжлэн үнэлж, сайжруулж байх</li> <li>Хөтөлбөрөөс гарах үр дүн зэргийг тодорхойлоход хамааралтай оролцогч талуудыг оролцуулсан байна.</li> </ul>	<p><b>1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага</b> Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.</p> <p><b>1.2. Хөтөлбөрийн зорилго</b> Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.</p>

Дээрх хүснэгтээс дүгнэхэд А шалгуур нь тухайн дэд шалгуурыг тус тусад нь үнэлэх, хэмжээсжүүлэх боломжтой бие даасан нарийвчилсан 5 шалгуурт хуваасан байна. Харин В шалгуур нь хэдийгээр хэрэгцээ шаардлага, зорилгыг тус бүрд нь дэд шалгуур болгосон ч нэг шалгуурт хэд хэдэн зүйлийг үнэлэх байдлаар томъёолсон байна. Тухайлбал, хөтөлбөрийн зорилго нь 4 зүйлд нийцсэн байх шаардлагыг нэг шалгуур болгосон байгааг харж болно (Хүснэгт 4).

*Хүснэгт 4. Сургалтын ачаалал кредиттэй холбоотой шалгуурын харьцуулалт*

А шалгуур	В шалгуур
<p><b>2.2 Сургалтын ачаалал, кредит</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөрийн хугацааны төлөвлөлт нь сургалтын хугацааг хэтрүүлэхгүйгээр зэргийн боловсролоо эзэмших боломж, нөхцөлийг бүрдүүлсэн байх</li> <li>Кредит систем нь оюутны гүйцэтгэх сургалтын ачаалалд баримжаалсан байх</li> <li>Оюутны сургалтын ачаалалд танхимын сургалтаар, бие даан суралцах цагийг</li> </ul>	<p><b>2.1. Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл</b> Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.</p>

зэрэг тооцоолсон байх ба хөтөлбөрийн бүх хичээлд хамаарна	
---	--

А шалгуурт дурдсан суралцагчийн ачаалал, суралцах хугацааг төлөвлөх байдлыг шалгах шалгуур нь В шалгуурт шууд дурдагдаагүй бөгөөд ерөнхий байдлаар дурдагдсан байна. В шалгуурын 2.1 шалгуурт харгалзах “нотлох баримт” хэсэгт суралцагчийн цагийн ачаалал тооцсон судалгаа гэж дурдсан байна. (Б.Оюунчимэг, П.Оргилмаа, 2019).

*Хүснэгт 5. Хөтөлбөрийн хэрэгжилтэд чухал хэрэглэгдэхүүн болох хичээлийн хөтөлбөрийн талаарх харьцуулалт*

А шалгуур	В шалгуур
<p><b>2.1 Бүтэц, хичээлүүд</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хөтөлбөр нь хичээлүүдээс бүрдэх бөгөөд хичээл тус бүр нь суралцах болон багшлах үйл ажиллагааны нэгтгэл байх</li> <li>Хичээл бүрийн бүтэц нь сурах үр дүнг хангахад чиглэсэн, оюутан бүр өөрийн сурах үйлийг төлөвлөх (юуг анхаарах, хэрхэн юуг сурах) боломж олгосон байх (оюутны шилжилт хөдөлгөөн, ажлын туршлага гм)</li> <li>Хөтөлбөрийн зохион байгуулалт нь сургалтын төлөвлөгөөнд заасан хугацааг хэтрүүлэхгүйгээр суралцаж төгсөх боломжийг хангасан байх</li> <li>Хичээлийн хөтөлбөрөөс гарах үр дүн нь мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн үр дүн болон үндэсний хэмжээний багш бэлтгэх шаардлагад нийцсэн байх</li> <li>Дадлага нь мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн зайлшгүй хэсэг байх ба түүний бүтэц, агуулга, тохирцын чанарыг баталгаажуулсан байх</li> <li>Тухайн оюутны албан ёсны зэргийн сургалтаас гадуур олж авсан мэдлэг, чадвар, ололт амжилтыг хүлээн зөвшөөрдөг журамтай байх (энэ нь сургууль/хөтөлбөр хоорондын шилжилт хөдөлгөөнийг хялбар байдлаар зохицуулахад шаардлагатай)</li> </ul> <p><b>5.1 Хичээлийн танилцуулга</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн мэдээлэлтэй бүх багш, оюутан танилцах боломжтой байх ба дараах бүтэцтэй байвал зохино: <ul style="list-style-type: none"> <li>Хичээлийн код</li> <li>Хичээл тус бүрийг хариуцах хүн/нэгж</li> <li>Заах аргазүй, сургалтын ачаалал</li> </ul> </li> </ul>	<p><b>1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд</b></p> <p>Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна. (Нотлох баримт: Батлагдсан хөтөлбөр, хичээлийн хөтөлбөр)</p>

<ul style="list-style-type: none"> <li>• Кредит</li> <li>• Агуулга</li> <li>• Төлөвлөсөн/Хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагаа</li> <li>• Элсэлтийн болон шалгалтын журам, шаардлага</li> <li>• Үнэлгээний хэлбэр, үнэлгээний онооны хуваарилалт</li> <li>• Судлах материалын жагсаалт</li> <li>• Сүүлийн засвар хийсэн огноо</li> </ul>	
--	--

А шалгуур нь хичээлийн хөтөлбөрийн бүтэц, танилцуулга шаардлагыг илүү нарийвчилсан шалгуураар гаргасан бол В шалгуур нь нэг дэд шалгуурт бүгдийг хамруулсан шинжтэй байна. Өөрөөр хэлбэл, В шалгуурын хувьд хичээлийн хөтөлбөрийг үнэлэх талаар нотлох баримтад заасан ч хэрхэн үнэлэх шалгуур нь тодорхой бус ерөнхий байдлаар томъёологджээ.

### **Дүгнэлт**

Энэхүү харьцуулсан судалгааны хүрээнд олон улсын болон дотоодын 2 шалгуур, шаардлагын агуулга, чанарт тоон болон чанарын шинжилгээ хийлээ. Харьцуулсан шинжилгээний үр дүнд олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ASIIN байгууллагын шаардлага, БМИУЗ-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагууд нь ерөнхий бүтэц, агуулгын хувьд ойролцоо, харин нарийвчилсан шалгуурын дэс дараалал, ангилал, томъёоллын хувьд ялгаатай байна. Дотоодын магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага нь хэт ерөнхий, нэг шалгуурт хэд хэдэн зүйлийг зэрэг үнэлэхээр заасан бол олон улсын магадлан итгэмжлэлийн шаардлага нь нарийвчилсан шалгуур бүрээр тодорхой нэг зүйлийг үнэлж, хэмжээсжүүлэх боломжтой байдлаар томъёологдсоноороо онцлог, ялгаатай байна.

Бакалаврын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлага нь тухайн хөтөлбөрөөр оюутан элсэхээс эхлээд төгсөх хүртэлх бүх процессын чанар, үйл явцад шинжилгээ хийх боломжтой байдлаар томъёологддог байна. Олон улсын шалгуурын хувьд илүү суралцагч, түүний суралцах, төгсөх боломж, суралцах үйл явцад төвлөрч үнэдэг байна. Мөн уг шалгуурын хувьд дэд бүлгүүд болон нарийвчилсан шалгуурууд хоорондоо давхцалгүй бөгөөд тодорхой, мөн логик дараалал, уялдаа холбоо сайтай тал ажиглагдсан. Дотоодын магадлан итгэмжлэлийн шалгуурын хувьд бакалаврын хөтөлбөр, түүний хэрэгжүүлэх үйл явцыг цогц системээр нь харж үнэлэхэд чиглэсэн бөгөөд бие даасан бүлэг тус бүрийн хувьд оновчтой үнэлгээ дүгнэлт хийх боломжтой байдлаар томъёологджээ. Гэвч бүлгүүдийг хэт салангид авсан, нотлох баримтуудыг зааж өгсөн ч уг баримтыг ямар шалгуураар үнэлэх нарийвчилсан шалгуур байхгүй зэрэг сул тал байна.

БМИУЗ-өөс хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ач холбогдлыг тайлбарлахдаа сургалтын чанар тасралтгүй сайжирна, олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөнө, суралцагчид нь үргэлжлүүлэн суралцах, тэтгэлэгт хамрагдах боломж өснө гэжээ. ASIIN байгууллагын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуурт тайлбарлахдаа мэргэжилтэн бэлтгэх хөтөлбөрийн үр дүн буюу оюутны эзэмших мэдлэг, чадвар, цогц чадамж болон үүнд хичээл тус бүрийн оруулах хувь нэмэр хоёрын

хоорондын холбоо хамаарлыг тодруулахыг чухалчилсан байна. Энэхүү хоёр дүгнэлтээс хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага нь юуг илрүүлэх зорилго тавьснаасаа шууд хамаарч ялгаатай байдлаар томъёологдсон байна гэж дүгнэж болохоор байна. Цаашид хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зорилго, ач холбогдлоос хамаарч шалгуур хэрхэн өөрчлөгдөж болох талаар үргэлжлүүлэн судлах шаардлага байна.

## ХОЁР. МАГАДЛАН ИТГЭМЖЛЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ АРГА ЗҮЙ

Гадаадад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн багш боловсролын хөтөлбөрүүдийн ерөнхий мэдээлэлд анализ дүгнэлт хийх, төлөвлөж, боловсруулсан багц хөтөлбөрийн бодит хэрэгжилтэд үнэлэлт өгөх зорилготой арга зүйг дараах зураглалаар харуулав.

Зураг 1. Арга зүйн бүрдэл



Ерөнхий арга зүйн бүрдүүлбэр хэсэг тус бүрийн хувьд үнэлгээний ямар асуултад хариулт авах болон үнэлгээний арга хэрэгслийг боловсруулав.

### 2.1. Ерөнхий шинжилгээ

2.1. Ерөнхий шинжилгээ	
Зорилго	Үнэлгээний асуулт
Гадаадад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийн ерөнхий мэдээллийг цуглуулж, анализ дүгнэлт хийх зорилготой.	Нэг. Ерөнхий мэдээлэл -Хөтөлбөр хэрэгжүүлж буй сургууль, хөтөлбөрийн нэр, индекс, хэрэгжиж эхэлсэн хугацаа, хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн огноо? Хоёр. Хөтөлбөрийн төлөвлөлт -Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага, зорилго (PEO), зорилт (PLO), нийт хичээлийн үр дүнгийн тоо? - Ижил хөтөлбөр хэрэгжүүлдэг гадаад дотоодын их дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулсан байдал? Гурав. Сургалтын төлөвлөгөөний бүтэц

	<p>-Ерөнхий суурь, багш боловсрол, Мэргэжил, багш мэргэжлийн дадлагын заавал болон сонгон судлах хичээлийн харьцаа?</p> <p>Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт</p> <p>-Хөтөлбөрөөр суралцагчийн тоо?</p> <p>-Хөтөлбөрт хичээл заадаг багшийн тоо?</p> <p>Тав. Оюутны хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа</p> <p>-Үйл ажиллагааны зорилго, хэрэгжүүлэгч, хамрах хүрээ, давтамжийн тоо?</p> <p>Зургаа. Багшлах дадлагын удирдлага, зохион байгуулалт</p> <p>-Дадлагын кредит, үргэлжлэх хугацаа, хамтран ажилладаг байгууллагын тоо?</p> <p>-Багш мэргэжлийн дадлага зохион байгуулалтын зураглал?</p> <p>-Хөтөлбөрийн хэрэгжилт үнэлэх үйл ажиллагаа, судалгаа?</p> <p>-Онцлох аргазүй?</p>
--	---

Үнэлгээний арга, хэрэгсэл:

- Хөтөлбөрийн талаарх шаардлагатай мэдээллийн хүснэгт

## 2.2. Хичээлийн иж бүрдлийн шинжилгээ

Сургалтын хөтөлбөрийн үр дүнг тодорхойлох хэсгийн нэг болох хичээлийн иж бүрэн тогтолцоот баримт бичгийн боловсруулалтад үнэлгээ өгөх зорилготой. Хичээлийн иж бүрдлийн шалгуурт хичээлийн стандарт, хөтөлбөр, хичээлийн үндсэн материал, суралцагчийн бие даан гүйцэтгэх ажил, үнэлгээний даалгаврын сан, цахим хичээл, сурах бичиг зэрэг орно.

2.2. Хичээлийн иж бүрдлийн шинжилгээ	
Шалгуур, шаардлага	Үнэлгээний асуулт
- Хичээлийн стандартыг сургуулийн баталсан загварын дагуу боловсруулсан байна.	<p>- Тухайн хичээлийн стандартаар суралцагчийн эзэмшсэн байх мэдлэг, чадвар, хандлагыг хэмжигдэхүйц, ойлгомжтой томъёолсон эсэх</p> <p>- Суралцахуйн үр дүн, үйл явцтай уялдсан үнэлгээний хэлбэр, даалгаврыг тодорхойлсон эсэх</p> <p>- Хичээлд судлах үндсэн сурах бичиг, материалуудыг шинэчилсэн байдал (хэвлэсэн он)</p> <p>- Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагын уялдаа холбоог агуулгын тогтолцоот бүрэлдэхүүн хэсэгт (хичээлийн жишиг төлөвлөгөөнд) тодорхойлсон эсэх</p> <p>- Арга зүй нь хичээлийн задаргаа болон онцлогт нийцсэн эсэх</p> <p>- Үнэлэх хэлбэр, бие даалтын тоо нь хичээлийн агуулга кредитийн хэмжээ, цагийн задаргаатай тохирсон эсэх</p>

- Хичээлийн хөтөлбөрийг сургуулийн баталсан загварын дагуу боловсруулсан байна.	- Хичээлийн хөтөлбөрийг тухайн хичээлийн стандартыг баримтлан боловсруулсан эсэх - Хичээлийн агуулга нь хичээлийн суралцахуйн үр дүнтэй (CLO) уялдсан эсэх - Хичээлийн хөтөлбөрт багшийн болон суралцагчийн гүйцэтгэх үйл ажиллагааг суралцахуйн онол, зарчимд нийцүүлэн алхамчлан төлөвлөсөн эсэх - Оюутны мэдлэг бүтээх үйл явцыг дэмжсэн унших материалыг хичээлийн сэдэв бүрээр тусгасан эсэх - Хичээлийн үнэлгээг хүрэх үр дүн болон кредит, цагийн задаргаанд нийцүүлэн төлөвлөсөн эсэх
Хичээлийн үндсэн материал нь лекц, семинарын материал, лабораторийн ажил болон дадлага хичээлийн удирдамжтай боловсруулсан байна.	- Хичээлийн үндсэн материал, боловсруулалт оновчтой эсэх
Сурах бичиг	- Үндсэн сурах бичиг, гарын авлагатай эсэх
Суралцагчийн бие даан гүйцэтгэх ажил	- Суралцагчийн бие даалтын ажлын тоо, хэлбэр, агуулга оновчтой эсэх
Цахим хичээл	- Цахим хичээлийн бүрдэл, цахим контент боловсруулж ашиглаж буй байдал
Үнэлгээний даалгаврын сан	- Үнэлгээний хэлбэр, үнэлгээний даалгаврын сан оновчтой эсэх

#### Үнэлгээний арга, хэрэгсэл:

- Бичиг баримтын шинжилгээ
- Хичээлийн иж бүрдлийн шалгуур тус бүрийг шинжлэх:
  - хавсралт 1. Хичээлийн стандарт
  - хавсралт 2. Хичээлийн хөтөлбөр
  - хавсралт 3. Хичээлийн үндсэн материал
  - хавсралт 4. Сурах бичиг
  - хавсралт 5. Суралцагчийн бие даан гүйцэтгэх ажил
  - хавсралт 6. Цахим хичээл
  - хавсралт 7. Үнэлгээний даалгаврын сан
  - хавсралт 8. Багшлах дадлага

### 2.3. Хичээлийн чанар, багшийн арга зүй

Их сургуулийн тэр дундаа багш бэлтгэх их сургуулийн хичээл нь ирээдүйн багш нарт сүүлийн үеийн шинэлэг арга зүй, насанд хүрэгчдийн сурах арга барил, хэрэгцээнд нийцсэн арга зүй, хэрэглэгдэхүүнийг ашиглан лекц, семинар, лаборатори, дадлага ажил гэх мэт

хэлбэр тус бүрийн онцлогийг харгалзсан байх шаардлагатай болж байна. Иймд хэрэгжилтийн судалгааны энэхүү хэсэгт сургалтын хөтөлбөрт туссан арга зүй, зарчим нь анги танхимд хэрхэн хэрэгжиж, багш оюутанд хэрхэн үр нөлөө үзүүлж байгаа, хөтөлбөрийн болон хичээлийн зорилго, зорилтод хэрхэн нийцэж байгааг тодруулах зорилготой.

<b>2.3. Хичээлийн чанар, түүний шинэчлэл</b>	
<b>Шалгуур, шаардлага</b>	<b>Үнэлгээний асуулт</b>
Хичээл нь хэлбэр тус бүрийн онцлогт нийцсэн, суралцагчид сүүлийн үеийн арга зүй, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэх жишиг болохуйц, тэдний хэрэгцээ, нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, уламжлалт хэлбэрээс татгалзсан байх	Хичээлийн хөтөлбөр дэх арга зүй, сургалтын арга, түүний хэрэгжилт анги танхимд бодитой хэрэгжиж байгаа эсэх? Хичээл нь суралцагчийг шинжлэн судлах, эрэл хайлт хийх, мэдлэгээ бүтээхэд хөтлөх арга зүй, даалгавруудыг агуулсан эсэх? Сургалтын агуулга нь орчин үеийн судалгаанд суурилсан байх ба түүний нийцлийг хэрхэн магадалдаг вэ?
Багшийн арга зүй нь шинэлэг, сурагчдаар мэдлэг бүтээлгэх, бие даан суралцах арга барил эзэмшихэд нь чиглэдэг байх	Сургалтад ашиглаж буй аргазүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэдэг үү? Сургалтын аргазүйн үр дүнд судалгаа хийж сайжруулдаг уу? Сургалтын тэгш, хүртээмжтэй арга зүйд суралцдаг эсэх? Цахим болон онлайн хичээлд Тонгоруу сургалтын аргыг хэрэгжүүлж буй эсэх (Flipped learning Classroom) Сургалтын арга зүй зарчим нь сонголт хийх, боломж олгох, бие даан суралцах нөхцөлийг хангасан эсэх?

#### **Үнэлгээний арга хэрэгсэл:**

- Лекц, семинар, лаборатори хичээлд ажиглалт хийх хуудас
- Хичээлийн дараа авах багш, сурагчийн асуулгын хуудас
- Хичээлийн арга зүй, түүнийг хэрхэн хөгжүүлж буй талаар багштай хийх ярилцлагын удирдамж

## **2.4. Хандлага, сэтгэл ханамж**

Суралцагч болон төгсөгчийн сэтгэл ханамж, хандлагыг илрүүлэхийн тулд асуулга боловсруулан авахаар шийдсэн болно.

<b>3.4. Хандлага, сэтгэл ханамж</b>	
<b>Шалгуур, шаардлага</b>	<b>Үнэлгээний асуулт</b>



Хөтөлбөрөөр суралцагч болон төгсөгч нь хөтөлбөрийн чанар, хичээлийн чанар сургалтын орчин, багшийн арга зүйн талаар сэтгэл ханамжтай байх	Хөтөлбөрийн чанар, сургуулийн сургалтын орчин, хичээлийн чанар, багшийн арга зүйн талаарх сэтгэл ханамж
---	---

Санал асуулгыг хөтөлбөр хэрэгжүүлэгч багш, хөтөлбөрийн төгсөгч, суралцагч оюутнуудаас хөтөлбөрийн чанарын талаарх сэтгэл ханамж, мэдээллийг цуглуулахаар төлөвлөсөн. Санал асуулгын асуулт бүр хаалттай байдлаар боловсруулагдсан ба асуулт бүрийн дараа нээлттэй асуултаар оролцогчийн нэмэлт санал, мэдээллийг авахыг зорьсон.

Асуулга бүр ерөнхий мэдээлэл, хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчин, багшлах боловсон хүчний талаар оролцогч тал өөрийн үнэлгээг өгөх боломж бүрдсэн. Үүгээр хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчин, боловсон хүчний чанар, багшлах, үйлчлэх ур чадварын талаарх оролцогчдын сэтгэл ханамжийн үнэлгээг харьцуулах боломжтой.

### **1. Хөтөлбөрийн чанар**

- a. Их сургуулийн бодлого
- b. Сургалтын төлөвлөгөөний хичээл, тэдгээрийн агуулга, уялдаа холбоо
- c. Оюутны эзэмшиж буй мэдлэг, чадвар
- d. Үнэлгээ
- e. Багшлах дадлагын чанар, уялдаа холбоо

### **2. Сургалтын орчин**

- a. Анги танхимын орчин
- b. Номын сан
- c. Интернэт орчин
- d. Техник тоног төхөөрөмж
- e. Онлайн хичээлийн нөөц

### **3. Багшлах боловсон хүчин**

- a. Багшийн хүрэлцээ
- b. Багшийн мэргэшсэн байдал, багшлах ур чадвар
- c. Багшийн харилцаа
- d. Багшийн оюутны дэмжиж буй байдал
- e. Багшийн эрдэм шинжилгээний чадвар гэсэн мэдээллийг харах боломжтой.

## **2.5. Нэгдсэн үнэлгээ**

Өнөөгийн байдлаар багш бэлтгэх хөтөлбөрөөр төгсөгч нь шууд багшлах эрхтэй төгсөж байгаа. Өмнө нь багшлах эрхийн шалгалт авдаг байсан. Багш боловсролын хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэхийн тулд нэгдсэн сорил авч, шинжилгээ хийхийг зорьсон болно.

### **2.5. Хандлага, сэтгэл ханамж**

Шалгуур, шаардлага	Үнэлгээний асуулт
<p>Магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрийн “хүрэх үр дүн”-тэй багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага хэрхэн нийцэж байгааг тодорхойлох</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Багш мэргэжилтний үнэт зүйл, итгэл үнэмшил, ёс зүй, харилцааны чадвар</li> <li>- Багш боловсролын мэдлэг, чадвар</li> <li>- Багшийн мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлага</li> </ul>

## ГУРАВ. ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН, ДҮГНЭЛТ

### 3.1. Ерөнхий шинжилгээ, үр дүн, дүгнэлт

Ерөнхий шинжилгээ хийхийн тулд 2022 оны 3 сарын 9-ний өдөр АХБ-аар уламжлан багш бэлтгэх албан бичиг илгээж, ерөнхий мэдээлэл цуглууллаа.

(Хавсралт №1. Албан бичиг).

Ерөнхий мэдээллийг магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэх хөтөлбөр бүхий төрийн болон төрийн бус өмчийн их сургуулиудаас цуглуулсан болно.

Хүснэгт 1. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн давтамж (тоогоор)

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС
1	Хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн давтамж	2	1	1	1	1	2

Ерөнхий мэдээлэлд хамаарагдах сургуулиудын өмчийн харьяаллыг харьцуулбал: Төрийн өмчийн сургууль 3, хувийн хэвшлийн сургууль 3 байна. Багш боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн давтамж 1-2 байна. Үүнээс харахад их дээд сургуулиудын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орсон туршлага багатай гэж үзэхээр байна. Нөгөө талаас улсын хэмжээнд хөтөлбөрийн магадлан итгэмжлэх үйл ажиллагааны цар хүрээ, сургуулиудын идэвх оролцооны үйл явцаас хамааралтай байна. Иймд багш боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл үйл ажиллагаанд өргөнөөр оролцуулах, их дээд сургуулиуд хооронд туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай байна.

### Хоёр. Хөтөлбөрийн төлөвлөлт

2.1 Мэдээлэл ирүүлсэн багш бэлтгэх их дээд сургуулиудын хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагын агуулга болон тоон мэдээллээс харахад дараах байдлаар нэгдмэл байр сууртай байна. (Хүснэгт 2 ба хавсралтаар оруулав) Үүнд:

1. Боловсролын салбарын хууль эрх зүйн баримт бичиг, засгийн газрын тогтоол шийдвэрт нийцсэн хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлагыг томъёолсон байна. Жишээлбэл:
  - Боловсролын тухай багц хуулиуд
  - Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого
  - Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого 2014-2024
  - Дээд боловсролын хөгжлийн бодлогын зорилт 2021
  - Монгол улсын засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд
  - "Зөв монгол хүн" шинэчлэлийн хөтөлбөр зэрэг байна.
2. Боловсролын салбарт сургууль тус бүрийн бэлтгэж буй мэргэжлээр чадвартай багшлах боловсон хүчнээр хангах хэрэгцээ үүссэн. Ерөнхий боловсролын чанар хүртээмж, багшлах боловсон хүчний эрэлт хэрэгцээг тусгахыг хичээсэн байна.
3. Их сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний таатай орчин бүрдэх шаардлага. Монгол суралцагчдад нийцсэн сургалтын хэв маяг, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх сургалтын чанар зэрэгт хүрэхийг эрмэлзсэн байдал нь нэгдмэл байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөрийн төлөвлөлтийн бүтэц (тоогоор)*

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС	Дундаж
1	Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага	5	1	2	3	1	5	3
2	Хөтөлбөрийн зорилго (PEO)	11	1	2	4	-	1	3
3	Хөтөлбөрийн зорилт (PLO)	15	38	17	12	-	4	14

2.2 Хөтөлбөрөөр хэрэгжих нийт хичээлийн үр дүнгийн тоог дийлэнх сургуулиуд тооцоолон гаргаагүй байна. Энэ нь хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орсон туршлага бага байгаатай холбож болох юм. Багш бэлтгэх сургуулийн хувьд оюутны заавал болон сонгон судлах нийт хичээлээр эзэмших МЧХ төлөвлөх шаардлагатай. Үүнд:

- Хувь хүний мэдлэг, чадвар, хандлага
- Багш боловсролын мэдлэг, чадвар, хандлага
- Академик мэдлэг, чадвар, хандлагын тоон үзүүлэлт, үр дүнг тооцоолох нь сургалтын үйл ажиллагаанд шинжилгээ хийх, хичээлийн агуулгаа сайжруулах ач холбогдолтой.

*Хүснэгт 3. Нийт хичээлийн үр дүнгийн тоо (CLO)*

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС
1	Хувь хүний мэдлэг, чадвар, хандлага	315	18	-	-	-	-
2	Багш боловсролын мэдлэг, чадвар, хандлага	381	15	-	-	-	-
3	Академик мэдлэг, чадвар, хандлага	279	3	-	-	-	-

**Гурав. Сургалтын төлөвлөгөөний бүтэц**

3.1 Тайланд орсон бүх сургуулиудын ерөнхий суурь хичээлийн хичээлийн болон кредитийн тоо ойролцоо байгаа нь их дээд сургуулиудын нийтээр даган мөрдөж байгаа шийдвэртэй холбоотой байна. Харин багш боловсролын суурь хичээлийн болон кредитийн тоо зарим сургуулиудынх өндөр байгаа нь тухайн багш мэргэжлийн мэргэжүүлэх хичээлийн онцлогоос хамаарч байна. Тухайлбал: Урлаг болон археологийн салбартай холбоотой хичээлийн болон кредитийн тоо харьцангуй өндөр байна. (Хүснэгт 4 ба 5) Багш мэргэжлийн дадлагын хувьд тайланд орсон бүх сургуулиудын дадлагын тоо ялгаатай байгаа хэдий ч кредитийн хувьд ойролцоо байна. Энэ нь тухайн сургуулийн байршил, мэргэжлийн онцлог болон оюутны тооноос хамааралтай байх боломжтой байна.

Хүснэгт 4. Сургалтын төлөвлөгөө дах заавал судлах хичээлийн тоо

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС	Дундаж
1	Ерөнхий суурь	11	12	10	12	10	8	10.5
2	Багш боловсрол	6	7	15	25	7	11	12
3	Мэргэжил (мэргэшил)	22	9	21	21	27	19	20
4	Багш мэргэжлийн дадлага	4	3	5	4	3	2	3,5

Хүснэгт 5. Сургалтын төлөвлөгөө дах заавал судлах кредитийн тоо

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС	Дундаж
1	Ерөнхий суурь	21	36	23	29	19	20	25
2	Багш боловсрол	14	24	28	31	16	28	23,5
3	Мэргэжил (мэргэшил)	61	30	40	32	62	47	45
4	Багш мэргэжлийн дадлага	13	12	15	13	13	12	13

3.2 Сонгон судлах хичээлийн кредит ялгаатай байгаа хэдий ч хичээлийн тооны хувьд ойролцоо байна. Энэ нь тухайн сургуулийн багшлах боловсон хүчний хүрэлцээ хангамж, орон нутгийн сургуулийн онцлог, мэргэшлийн онцлог болон оюутны тооноос хамааралтай байх боломжтой байна. (Хүснэгт 6 ба 7)

Жич: Сонгон судлах хичээлийн агуулга харилцан адилгүй байгаа тул багш боловсрол, мэргэшилтэй холбоотой мэдээлэлд үнэлгээ, дүгнэлт өгөх, таамаглал дэвшүүлэх боломжгүй байгаа болно.

Хүснэгт 6. Сургалтын төлөвлөгөө дах сонгон судлах хичээлийн тоо

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС	Дундаж
1	Ерөнхий суурь	4	3	6	4	6	5	7
2	Багш боловсрол	4	2	4	4	4	4	4
3	Мэргэжил (мэргэшил)	8	5	8	2	10	2	9

*Хүснэгт 7. Сургалтын төлөвлөгөө дах сонгон судлах хичээлийн кредитийн тоо*

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС	Дундаж
1	Ерөнхий суурь	9	9	12	7	11	13	8
2	Багш боловсрол	10	6	11	14	14	3	9
3	Мэргэжил (мэргэшил)	11	15	15	5	15	11	9

**Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.**

Тайланд орсон сургуулиудын хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтын зураглал нь бүтэц, зохион байгуулалт, агуулга болон зорилгын хувьд харилцан адилгүй байгаа тул харьцуулалт боловсруулалт хийхэд хүндрэл үүссэн болно. Энэ нь цаашид нийт салбарын хэмжээнд нэгдсэн аргазүй, удирдамж болон зөвлөгөө шаардлагатай байгааг харуулж байна.

**Тав. Оюутны хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа**

Мэдээлэл ирүүлсэн багш бэлтгэх их дээд сургуулиудын *оюутны эрдэмжилт болон бүх талын хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа нийтлэг талууд ихтэй байна.*

- Төрөл бүрийн мэргэшил, спорт болон бусад уралдаан тэмцээн
- Оюутны эрдэм шинжилгээний болон бусад чиглэлийн клубийн үйл ажиллагаа
- Мэргэжил сурталчлах, карьер төлөвлөлттэй холбоотой үйл ажиллагаа
- Сайн дурын үйл ажиллагааг клубийн хэлбэрээр болон сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан хэрэгжүүлдэг байна.

Харин хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан үйлчилгээ, тэдэнд зориулсан суралцахуйн болон нийгэмшихүйн дэмжлэг тааруу, оюутан солилцоо, гадаадын их сургуульд тэтгэлгээр суралцах боломж хязгаарлагдмал байна. (*Хүснэгт 8*)

*Хүснэгт 8. Оюутны хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа*

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС	Нийт
1	Оюутан солилцоо, гадаадын их сургуульд тэтгэлгээр суралцах боломж	+	+					2
2	Мэргэжил сурталчлах, карьер төлөвлөлт	+	+	+		+	+	5
3	Сайн дурын үйл ажиллагаа	+		+	+		+	4
4	Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудад зориулсан үйлчилгээ	+	+					2

5	Клубийн үйл ажиллагаа	+	+		+	+	+	5
6	Уралдаан тэмцээн	+	+	+	+	+		6

### **Зургаа. Багшлах дадлагын удирдлага, зохион байгуулалт.**

Багш мэргэжлийн дадлагын кредитийн хэмжээ ойролцоо байгаа боловч, нэршил, хүрэх үр дүн, тоо болон судлах хугацаа харилцан адилгүй байна. Харин ялгаатай байдал нь дараах хүчин зүйлээс хамааралтай байж болохоор байна. (*Хүснэгт 8 ба хавсралт*)

- ЕБС-тай хамтран ажиллах хэлбэр болон мэргэшлийн онцлог
- Тухайн сургуулийн байршил болон өмчийн хэлбэр
- Тухайн мэргэжлээр элсэн суралцаж буй оюутны тооноос хамааралтай байх боломжтой байна.

### *Хүснэгт 9. Дадлагын кредитын хуваарилалт*

№	Харьцуулах үзүүлэлт	МУБИС	МУИС	ДИС	СУИС	ХИС	ОТИС	Дундаж
1	Танилцах дадлага	1	2	1	1	1	-	1
2	Судлах дадлага	2	-	2	4	-	-	1.3
3	Дагалдан суралцах дадлага	-	-	3	-	-	-	0.5
4	Туршин заах дадлага	4	4	4	4	4	4	4
5	Багшлах дадлага	4	6	5	4	8	10	6

### **Долоо. Сургуулиудын онцлох сургалтын технологийн шинэчлэл, арга зүй**

#### **А. Сургалтын хөтөлбөрийг арга зүйн хувьд шинэчлэх, хэрэгжүүлэх зарчим**

- Боловсролын болон математикийн шинжлэх ухааны дэвшилтэд онол, үзэл баримтлал, сүүлийн үеийн ололт амжилтад тулгуурлах,
- Онол практикийн нэгдмэл байдал, зохистой хослолыг хангах,
- Хүрэх үр дүнд суурилсан байх,
- Хийх явцдаа суралцах, оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлах,
- Суралцагч бүрийг хөгжүүлэх, тэдний сонирхол, хэрэгцээг харгалзах, нөөц боломжийг нь нээх,
- Суралцагчдын бүтээлч чадварыг хөгжүүлэх, бие дааж суралцах, мэдлэг бүтээх чадвар эзэмшүүлэх.

Б. Дурдсан зарчмыг баримтлан суралцагч төвтэй, багш оюутны оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурласан сургалтыг төлөвлөх, зохион байгуулах олон хувилбар байж болно. Санал болгож буй хувилбар:

1. Сургалтыг асуудал төвтэй зохион байгуулж, лекцээр тулгуур ухагдахуун, гол онол үзэл санаа, онолын ерөнхий үндэслэл, уншиж судлах болон ажиглах, судлан шинжлэх ажлын ерөнхий чиглэл гэх мэт аргазүйн зөвлөмж өгч бие дааж ажиллах баримжаа олгох,
2. Семинар, практикийн хичээлийг анги нийтээр, багаар болон хосоор, ганцаар ажиллах хэлбэрээр, шинэ мэдлэг бүтээх, мэдээлэл боловсруулах, санал солилцох, ярилцлага, маргаан, мэтгэлцээн, төлөвлөлт, туршилт, үнэлгээ, харьцуулалт хийх гэх мэт багш суралцагчдын шинэ мэдлэг бүтээх хамтын үйл байхаар зохион байгуулах,
3. Бие даасан болон дадлага ажил\хичээлийг ажиглалт, ярилцлага, кейс, эргэцүүлэл, шинжилгээ, эрэл хайгуул, мэдээ баримт цуглуулах, бүтээлийн сан бүрдүүлэх, үйлийн судалгаа, технологи боловсруулалт, туршилт хийх гэх мэт хэлбэртэй байхаар зохион байгуулах,
4. Багшлахуйг суралцагчдыг мэргэжлийн ажилд сэдэлжүүлэх, сурах үйлийг идэвхжүүлэх, мэдээлэл дамжуулах, мэдээлэлтэй ажиллуулах, зөвлөн туслах, хамтран ажиллах, харилцан зөвшилцөх, итгэл хүлээлгэх, шаардлага тавьж, хянах, үнэлэх зэрэг цогц үйл байхаар зохион байгуулах гэх мэт.
5. Үйлийн судалгааны аргыг хэрэгжүүлэх. Үйлийн судалгаа нь багшлах болон суралцахуйн өдөр тутмын үйл ажиллагаанд гарч буй өөрчлөлтийг ажиглаж асуудлыг дэвшүүлэн тавьж түүнийг шийдэх арга зүйгээ боловсруулан түүнийгээ шийдвэрлэдэг бөгөөд шийдвэрлэсэн арга замаа тодорхойлоход багш байнга бодож, эргэцүүлж, төлөвлөх шаардлага гардаг тул ингэснээрээ багш өөрөө байнга хөгжиж байдаг.

В. Сургалтыг ийм байдлаар зохион байгуулснаар суралцагчдыг хөгжүүлэх үйлст арга зүйн хувьд дараах давуу талууд бий болно. Үүнд:

1. Суралцагч бүрийн саналыг сонсож, тэдний мэдлэг, ойлголтын түвшин, хүсэл сонирхлыг мэдэж, цаашид гүнзгийрүүлэн хөгжүүлэх,
2. Суралцагчдын бие даасан үйл ажиллагаа, гүйцэтгэх даалгавруудыг нь шатлан өргөжүүлж хөгжүүлэх замаар тэдний сурахуйг дэмжих,
3. Судалгаа шинжилгээний аргад сургах замаар суралцагчдын судалгааны ажилд оролцох сонирхлыг төрүүлэх,
4. Суралцагчдын шүүмжлэлт сэтгэлгээний чадварыг хөгжүүлэх,
5. Бүлгээр болон ганцаарчлан ажиллуулах замаар бүх суралцагчдыг сурах үйл ажиллагаанд татан оролцуулах,
6. Эх сурвалжаа сонгох, шаардлагатай мэдээлэл олох, боловсруулах, бүтээлчээр сэтгэхэд туслах,
7. Судалгааны энгийн аргуудыг ашиглан тодорхой ухагдахуун, үйлийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх чадварт суралцуулах,
8. Аливаа зүйлийн учир холбогдлыг тайлах, шалтгааныг олох, гарах үр дүнг тооцох зэргээр өөрийн ойлголт, мэдлэг, чадварыг бий болгох,
9. Сурах үйлээ эргэцүүлэх, гарсан үр дүнг үнэлэх, зорилго, зорилтоо зөв томъёолох, цаашдын үйлээ төлөвлөх,
10. Өөрийн санаа бодлоо цэгцтэй илэрхийлэх, нотлох гэх мэт.



## Найм. Дүгнэлт

- Оюутны нийт хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг төлөвлөх нэгдсэн арга зүйтэй боловсруулах шаардлагатай байна.
- Оюутны багшлах ур чадвар, эрдэмжилт болон бүх талын хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа нийт багш бэлтгэх сургуулиуд хамтран зохион байгуулах, уламжлал болгох хэрэгцээ бий болсон байна.
- Багш мэргэжлийн дадлагын нэршил, хэлбэр, хүрэх үр дүн, тоо, судлах хугацаа, болон хамтран ажиллагч байгууллагын тоо харилцан адилгүй байна.
- Улсын хэмжээнд багш боловсон хүчин бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр харьцангуй цөөн байгаа тул идэвхтэй оролцуулах хэрэгтэй байна.
- Багш боловсролын хөтөлбөрийн магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын бүх талын хамтын ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Тодруулбал их дээд сургуулиуд хоорондоо багш боловсролын заавал судлах хичээл болон бүх төрлийн дадлагын талаар туршлага солилцох, хамтын ажиллагааг хөгжүүлэх шаардлагатай байна.

## 3.2. Хичээлийн хөтөлбөрийн шинжилгээ, үр дүн, дүгнэлт

*Хичээлийн хөтөлбөрийн шинжилгээ нь:*

- Хичээлийн стандарт;
- Хичээлийн хөтөлбөр;
- Үндсэн сурах бичиг (гарын авлага);
- Хичээлийн үндсэн материал;
- Суралцагчийн бие дааж гүйцэтгэх ажил;
- Цахим хичээл;
- Үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэлт;
- Багшлах дадлага гэсэн 8 шалгуур бүхий хичээлийн иж бүрдлээр багш боловсрол, мэргэжлийн дидактик, мэргэжлийн тус бүр нэг нэг хичээлийг сонгон хийсэн.

### 1. *Хичээлийн стандартад хийсэн шинжилгээний үр дүн:*

Сургууль бүр сургалтын хөтөлбөрийн стандартуудыг нэгтгэн хэвлүүлэн хавтасласан байна. Зарим сургууль түүнийгээ оюутнуудад зориулсан гарын авлага болгосон нь оюутанд судлах хичээлийн товч агуулгатай танилцах боломжтой харагдаж байна. Зарим сургууль багшийн веб дээр хичээл сонголтын өмнө орох хичээлийнхээ стандартыг тавьсан байна.

Хичээлийн суралцахуйн үр дүн харилцан адилгүй байгаа нь ажиглагдлаа. Тухайлбал,

- 4 кредит цаг судлах хичээлд нийт 8,
- 3 кредит цаг судлах хичээлд нийт 3-18,
- 2 кредит цаг судлах хичээлд нийт 6-12 үр дүнг дэвшүүлсэн нь нэг 1 кр хичээлд дунджаар 9 мэдлэг, чадвар, хандлага оногдохоор байна. Энэ нь 1 кр хичээлийн суралцахуйн үр дүнг баримжаалсан тоо өгөхгүй бол оюутанд нийт суралцахуйн үр дүн хэт их ачаалал болох магадлалтай.

Хичээлийн үр дүн (CLO)-г танин мэдэхүйн түвшнээр ихэнх сургууль бага тодорхойлсон байна. Ирц, оролцоо, бие даалтын тоо, явцын үнэлгээ нь (эзлэх хувь) хичээлийн агуулга, кредитийн хэмжээ, цагийн задаргаатай (онол, практик) сургууль болгон өөрийн онцлогт тохируулан янз бүрээр тодорхойлсон байна.

### 2. *Хичээлийн хөтөлбөрт хийсэн шинжилгээний үр дүн:*

Хичээлийн хөтөлбөрийг сургуулийн баталсан загварын дагуу боловсруулж, хөтөлбөрийн хороогоор хэлэлцэж батлуулсан, хичээлийн стандарт ба хөтөлбөр нь хоорондоо тохирч нийцэж байна.


Хичээлийн хөтөлбөрт сургалтын идэвхтэй олон арга зүйг тусган ашиглаж, суралцагчийн суралцах үйл явцыг тодорхой, оновчтой төлөвлөх тал дээр зарим сургуулийн хичээлийн хөтөлбөрт ажиглагдсангүй.

Ихэнх сургуулийн хичээлийн хөтөлбөрт суралцагчийн гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний шалгуурыг тодорхой тусгасан нь оюутан өөрийгөө, хөндлөнгийн үнэлгээ хийх боломжоор хангагдсан байна.

Хичээлийн агуулгын шинэчлэлийн талаар хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нараас судалгаа авсан. Энэ судалгаанд Биеийн тамирын сургуулийн (Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрийг хэрэгжүүлэгч) 23 багш хамрагдсан. Биеийн тамирын багш хөтөлбөрийг онцлон судалгаа авсан нь гадаадад болон дотоодод магадлан

итгэмжлэгдсэн багш мэргэжлийн 37 хөтөлбөрүүдээс практик хичээл зонхилсон ганц хөтөлбөр байсан.

Зураг 1. Хичээлийн агуулгад холбогдох судалгааны асуултад багш нарын хариулсан байдал (багшийн тоо)



Зургаас ББТБ хөтөлбөрт агуулгын шинэчлэл хийгдсэн бөгөөд тэр нь хөтөлбөрийн болон хичээлийн үр дүнтэй нийцэж байна.

Асуулгын судалгааны цөөн тооны сөрөг хариултыг тодруулбал, “Биеийн тамирын сургалтын арга зүй I, II” хичээлийн зарим агуулга (жишээ нь, биеийн тамирын хичээл төлөвлөлтийн сэдэв) нь спортын тодорхой төрлийн арга зүйн хичээлийн зарим агуулгатай давхарддаг гэсэн хариултыг 2 багш өгснийг нягталж үзвэл агуулгын шууд давхардал харагдаагүй бөгөөд спортын тухайн төрлийн хичээлийн онцлогт тохирсон агуулга байгаа нь ажиглагдлаа.

Таны заадаг хичээлийн хэлбэр нь онол, практикийн зохистой харьцааг хангасан уу? гэсэн асуултад 23 багшаас 2 багш үгүй гэсэн сөрөг хариулт өгсөн. Тэдний нэг багш нь мэргэжлийн хичээлийг судлах кредитийн хэмжээ бага байдгаас волейбол хичээлийн онол, практикийн харьцаа тохиромжгүй гэсэн байна. Нөгөө нэг багш нь Хүний биеийн бүтэц зүй, Спортын анагаах ухаан, Спортын биохимийн хичээлийг лаборатори хэлбэрээр орох нь зүйтэй гэж үзсэн. Тус хөтөлбөрийн агуулга дахь эмнэлэг-анагаах ухааны чиглэлийн хичээлүүдийг заадаг бусад багш нар (3 багш) эдгээр хичээлийн онол, практикийн харьцааг зохистой гэж үзсэн ба “Спортын анагаах ухаан” хичээл нь сургалтын төлөвлөгөөнд лекц, лаборатори хэлбэрээр тавигдсан байна. Цаашид “Хүний биеийн бүтэц зүй”, “Спортын биохими” зэрэг хичээлийг зайлшгүй лаборатори хэлбэрээр орох шаардлагатай гэж үзвэл лаборатори байгуулах талаар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой гэж үзсэн.

Хичээлийн агуулгын шинэчлэл нь хөтөлбөрийн (PLO) ба хичээлээр хүрэх үр дүн (CLO)-тэй нийцэж уялдаж байгаа байдлыг судалгаанд хамрагдсан багш нар өөрсдөө 100% нийцнэ гэж үзсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний багаас мэргэжлийн заавал судлах болон сонгон судлах хичээлээс доорх хичээлүүдийн стандарт болон хөтөлбөрийн нийцлийг шалгаж үзсэн. Эндээс дараах байдал ажиглагдлаа.

“Эрүүл биеийн физиологи” хичээл (мэргэжлийн хичээл):

Академик мэдлэг, чадвар, хандлагын шинэчилсэн PLO-г ашиглаж хичээлийн хөтөлбөрийг шинэчлээгүй байна. Лекцийн хичээлийн зорилгыг ихэвчлэн: судалж мэдэх, ойлгох, ...-ийг

мэдэх гэх мэтээр томъёолсон ба семинарын хичээлийн зорилго нь бусад чадварыг илэрхийлж байна. Энэ хичээлийн стандарт ба хөтөлбөр нь хоорондоо тохирч нийцэж байна.

“Биеийн тамирын сургалтын арга зүй – II” хичээл (мэргэжлийн дидактик хичээл):

Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO)-ыг судлах агуулгын бүлгээр тодорхойлсон учраас хичээлээр эзэмших цөм агуулгын хүрээ нь академик мэдлэг, чадварын PLO-д тохирч байна. Академик мэдлэг, чадвар, хандлагын шинэчилсэн PLO-г ашиглаж хичээлийн хөтөлбөрийг шинэчлээгүй байна. Лекцийн хичээлээр эзэмшсэн мэдлэгээ семинарын хичээлээр чадвар болгох байдлаар хичээл бүрийн зорилгыг тодорхойлсон байна. Энэ хичээлийн стандарт ба хөтөлбөр нь хоорондоо тохирч нийцэж байна. Хөтөлбөрийн болон хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг дэмжсэн арга зүй, хэрэглэгдэхүүнийг ашиглахаар байна.

“Хөнгөн атлетик – I” хичээл:

Хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлага (CLO)-ыг сургалтын хөтөлбөрийн шинэчилсэн PLO-той нийцүүлж шинэчилсэн байна. Энэ хичээлийн стандарт ба хөтөлбөр нь хоорондоо тохирч нийцэж байна. Хөтөлбөрийн болон хичээлээр эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг дэмжсэн алхмууд, арга зүй, хэрэглэгдэхүүнийг ашиглахаар байна. Эндээс “Багш, биеийн тамирын боловсрол” хөтөлбөрийн хичээлүүдийн стандарт болон хөтөлбөр хоорондоо нийцэлтэй байгаа нь харагдаж байна. Гэхдээ зарим хичээлийн ялангуяа спортын тодорхой төрлийн практик хичээлийн хөтөлбөрийн боловсруулалтыг сайжруулах шаардлага байна гэж үзлээ.

### **3. Үндсэн сурах бичиг (гарын авлага)-д хийсэн шинжилгээний үр дүн:**

Зарим сургуулийн хичээлийн агуулгыг хангасан бие даасан сурах бичигтэй, зарим нь үндсэн сурах бичиггүй байсан. Хөтөлбөрийн агуулгын тодорхой хэсгүүдээр гарын авлага, зөвлөмж боловсруулан оюутанд хэрэглүүлж байна.

Цахим хэлбэрээр байршуулсан сурах бичиг, мэдээллийн эх үүсвэр цөөн, эрдэм шинжилгээний бүтээлийг хөтөлбөрт тусгах нь бага байгаа нь ажиглагдсан. Тиймээс хөтөлбөрөөр суралцагчдын заавал судлах ном, сурах бичгийн албан ёсны жагсаалт чиглэлийг гарган, тэнхимийн эрхлэгч баталгаажуулан, оюутанд хүртээмжтэй болгох ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж үзсэн.

### **4. Хичээлийн үндсэн материалд хийсэн шинжилгээний үр дүн:**

Сургуулийн онцлогоос хамаарч зарим сургууль хичээлийн үндсэн материалаа гарын авлага болгон сургуулийнхаа номын санд өгсөн, зарим сургуульд хичээл тус бүрээрээ PPT хэлбэрээр судлах долоо хоног тус бүрээр хэвлэж, хавтасласан байна.

Хичээлийн үндсэн материалд тухайн хичээлээр үндсэн болон нэмэлтээр агуулгыг судлах ном, сурах бичиг, гарын авлагын хуудсыг зааж, бие даан суралцах үйлийг дэмжих боломжтой.

### **5. Суралцагчийн бие дааж гүйцэтгэх ажилд хийсэн шинжилгээний үр дүн:**

Бие даалтын удирдамж нь арга зүйн баримт бичиг мөн бөгөөд хичээл бүрээр оюутны бие даалтын ажлын удирдамжийг боловсруулан ашигладаг байна. Ялангуяа лаборатори хичээлийн удирдамжууд илүү тодорхой, ойлгомжтой боловсруулагдсан байна. Зарим сургуулийн мэргэжлийн дидактикийн хичээлээр оюутны бие даалтын ажлын дэвтэртэй бөгөөд энэ нь оюутанд бие даан суралцахад арга зүйн туслалцаа болдог байна. Зарим

сургуулийн хичээлийн хөтөлбөрт оюутны бие даалтын ажлын удирдамжид үнэлгээний рубриктэй байгаа нь оюутан өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж, дүн шинжилгээ хийх ач холбогдолтой байв.

#### 6. Цахим хичээлд хийсэн шинжилгээний үр дүн:

Ковид-19 цар тахлын улмаас 2019-2020 оны хичээлийн жил онлайнаар эхэлсэнтэй холбоотойгоор хичээл бүр контентоо интерактив, аудио, видео хэлбэрээр баяжуулсан цахим хичээлийн сантай болж, Teams, VOOV програмыг ашиглан, сургалтыг онлайнаар зохион байгуулж, явуулсан байна.

Хичээлийн явцын болон улирлын үнэлгээний аль нэгийг цахимаар авдаг байна. Цахим хичээлийн төлөвлөлт зарим хичээл дээр байсангүй.

Техник, тоног төхөөрөмжийн нөөц, боломжийг судалж, багш цахимаар сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээ авах, цахим хичээлд тавигдах шаардлага хангасан хичээлийн контентын чанарт анхаарах хэрэгтэй байна.

#### 7. Үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэлтэд хийсэн шинжилгээний үр дүн:

Үнэлгээний төрөл нь явцын болон улирлын үнэлгээтэй байсан. Тухайн сургуулийн мэргэжлийн онцлогоос хамаарч явцын үнэлгээ 20-30%-ийг улирлын үнэлгээ 20 % эзэлж байна. Үнэлгээний даалгаврын сан бүрдүүлэлт нь сургууль бүрд харилцан адилгүй байна. Тухайлбал, зарим сургуульд кредитийн тооноос хамаарч даалгаврын баримжаалсан тоотой (1 кр=50 даалгаврын сантай) байсан.

Зарим сургуульд өөр сургуулиас шилжиж ирэхэд авдаг, анги дэвшихэд, жилийн чөлөөнөөс ирэхэд авдаг даалгаврын сантай байна.


Зарим сургууль үнэлгээний даалгаврын тестийн цөөн (2) хувилбараар боловсруулсан байна.

Зарим сургуулийн мэргэжлийн хичээлийн үнэлгээний даалгаврын сангийн эмхэтгэлтэй байгаа нь оюутан бие дааж шалгалтдаа бэлтгэх, суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байна гэж үзсэн. Энэ талаар оюутнуудын дунд явуулсан бичил судалгааны дүнгээр харуулъя (зураг 2-4). Судалгаанд 1-4 курсийн нийт 110 оюутан, үүнээс 1-р курс 27.3%, 2-р курс 27.3%, 3-р курс 22.7%, 4-р курс 22.7% тус тус хамрагдсан.

Зураг 2. Оюутны мэдлэг, чадварыг хэрхэн үнэлэхээ багш урьдчилан танилцуулдаг байдал (%)



**Зураг 3. Оюутны мэдлэг, чадварыг ил тод, бодитой үнэлдэг эсэхэд өгсөн оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ**




Багш оюутны мэдлэг, чадварыг ил тод, бодитой үнэлдэг үү? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан оюутны 64.5% нь тийм, 10% нь ер нь тийм гэж хариулснаас “оюутныг бодитой үнэлж” байгааг харж болох боловч 4 оюутан буюу 3.7% нь бараг бодитой үнэлдэггүй гэж хариулсныг анхаарахгүй орхиж боломгүй. Энэ асуултад курсийн ялгаа ажиглагдаагүй болно.

**Зураг 4. Явцын үнэлгээний талаарх оюутны сэтгэл ханамжийн үнэлгээ**



**Зураг 5. Явцын үнэлгээг ахиулах боломжийн талаар авсан асуулгын дүн**




Оюутан явцын үнэлгээтэйгээ танилцаж, яагаад ийм үнэлгээ авснаа мэдэж, түүнийгээ ахиулах боломж нээлттэй байна. Энэ боломж анги ахих тутам нэмэгдэж байгаа нь оюутны сурах арга барил нөлөөлсөн байж болох талтай.

Суралцагчийн үнэлгээтэй холбогдох цөөн асуултаар багш нараас судалгаа авсан (зураг 6). Эндээс журамд заасны дагуу, үнэлгээний зарчмуудыг баримтлан оюутны

мэдлэг, чадварыг үнэлж байгаа бөгөөд хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн гэж багш нар үзэж байгаа нь харагдсан.

Зураг 6. Оюутны үнэлгээнд холбогдох судалгааны зарим үзүүлэлт (n=25 багш)



Харин цөөн багш цахим сургалтын явцад системээр шалгалт аваагүйн шалтгааныг: онлайн шалгалт авахаар бэлтгэж байна, практик хичээлийн шалгалтыг цахимаар авах боломжгүй гэж тайлбарласан. Судалгаанд хамрагдсан багш нарын 76% нь оюутны үнэлгээнд үндэслэн хөтөлбөртөө сайжруулалт хийдэг хэмээн хариулсан байна.


Лекц, семинарын хичээлээр оюутны эзэмшсэн мэдлэг, чадварыг тэдний танин мэдэхүйн түвшнийг илрүүлэх сорилын даалгавар болон бичиж боловсруулах даалгаврын гүйцэтгэлээр үнэлсэн байсан. Практик хичээлийн үнэлгээнд хөдөлгөөний тестийн аргыг ихэнхдээ ашиглаж байна. Тэдгээр үнэлгээний даалгаврууд тухайн хичээлээр оюутанд эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлага (CLO)-ыг агуулсан гэж үзэж болохоор байна. Багш, биеийн тамирын боловсрол хөтөлбөрийн үнэлгээний даалгаврын сангийн статистикт шинжилгээ хийж үзвэл, танин мэдэхүйн түвшин бүрд даалгавар боловсруулсан нь харагдсан. Судалгаанд хамруулсан 29 хичээлээр нийт 2287 үнэлгээний даалгавар боловсруулсны 19.7% нь сэргээн санах, 17.7% нь ойлгох, 25.9% нь хэрэглэх, 22.8% нь задлан шинжлэх, 6.5% нь үнэлэх, 7.4% нь бүтээх түвшний даалгавар байна. Үүнийг тохиромжтой гэж үзсэн. Багш бүр өөрийн заадаг хичээлээр гарааны үнэлгээ хийж, оюутны хөгжлийн ахицыг үнэлж байгаа нь судалгааны баримтаас харагдсан.

Зарим сургуулийн тухайн хичээлийн үнэлгээний даалгаврын сан нь танин мэдэхүйн түвшнээр боловсруулагдаагүй байна.

#### 8. Багшлах дадлагад хийсэн шинжилгээний үр дүн:

МУБИС-ийн багш бэлтгэх хөтөлбөрт багш боловсролын дадлагыг 1-4 дүгээр курсэд залгамж холбоотой оруулсан байна (зураг 6). Оюутан 1-р курстээ ирээдүйн багшийн нүдээр ерөнхий боловсролын сургуультай “танилцах дадлага”-ыг, 2-р курст “Судлах дадлага”-ыг оюутан хүүхдийн хөгжил төлөвшил, сэтгэл зүйн онцлог, анги-бүлгийн сэтгэл зүйн уур амьсгал, сурган хүмүүжүүлэх харилцаа болон багш, суралцагчийн сурах үйл ажиллагааг ажиглан судлах, 3-р курст “Туршин заах дадлага”-ыг багшийн чиглүүлгээр мэргэжлийн хичээлийг төлөвлөх, зааж турших, үнэлж эргэцүүлэхэд суралцаж, багшлах дадлага хийхэд шаардагдах чадвар эзэмших, 4-р курст “Багшлах дадлага”-ыг оюутан-багш бие дааж хичээл заах, сурагчийг үнэлэх, мэргэжлийн сургалтын арга зүйн чиглэлээр судалгаа хийхэд суралцах чадвар эзэмшихээр тусгасан байна.

Зураг 7. Дадлагын залгамж холбооны ерөнхий зураглал



Дадлагын дэвтрийг багш мэргэжлийн ба мэргэжлийн дадлагын дэвтэр гэсэн 2 дэвтэрт дадлагын стандартыг хангахад чиглэсэн удирдамж, зөвлөмжийг, оюутан-багш дадлагын хугацаанд ямар мэдлэг, чадвар эзэмшиж, хэрхэн төлөвшихийг тодорхой үйл ажиллагааны төлөвлөлтийн дагуу оруулж, дадлагын тайлан хамгаалалт, үнэлгээг багтаасан байна. Дадлагын явцад оюутан-багш уг дэвтэр дээр ажиллан, өөрийгөө хөгжүүлэх, дадлагаас суралцах бүрэн боломжтой болсноороо онцлог юм.

2015 оноос МУБИС-ийн оюутнууд орон нутагт БСШУЯ-ны тэтгэлэгт дадлагыг хийж, жил бүрийн багшлах дадлагын эцэст тайлан хамгаалалтад дадлагын шилдэг сургууль, багш, оюутныг шалгаруулан урамшуулдаг байна (Зураг 8).

Зураг 8. Багшлах дадлагын шилдэг оюутан-багш нарын шалгаруулалт



Бусад сургуульд танилцах, багшлах гэсэн 2 дадлагатай байна. Багшлах дадлагын дэвтэртэй байна.

### Дүгнэлт

- Хичээлийн стандартад дахь суралцахуйн үр дүн хичээл бүр дээр харилцан адилгүй 3-18 байна. Энэ нь 1 кр хичээлийн суралцахуйн үр дүнг баримжаалсан тоотой байвал оюутанд нийт суралцах хугацааны суралцахуйн үр дүн хэт их ачаалал болох магадлалтай.
- Хичээлийн хөтөлбөрийг сургуулийн хөтөлбөрийн дэд ба салбар хороогоор тодорхой үе шаттай хэлэлцэн, сайжруулж, баталгаажуулан хэрэгжүүлж байгаа нь хөтөлбөрийг чанаржуулах үйл явц тасралтгүй явагдаж байгааг харуулж байна.
- Хичээлийн хөтөлбөрийг сургуулийн баталсан загварын дагуу боловсруулж, хөтөлбөрийн хороогоор хэлэлцэж батлуулсан, хичээлийн стандарт ба хөтөлбөр нь хоорондоо тохирч нийцэж байгаа ч хичээлийн хөтөлбөрт сургалтын идэвхтэй олон арга зүйг тусган суралцагчийн суралцах үйл явцыг тодорхой, оновчтой төлөвлөх тал дээр анхаарч ажиллах шаардлагатай байна.
- Хичээл хэлбэр нь суралцагчийн эзэмших цогц чадамжид суурилсан, онол, практикийн зохистой харьцааг хангасан, залгамж холбоотой байна.



- Хөтөлбөрөөр суралцагчдын заавал судлах ном, сурах бичгийн албан ёсны жагсаалт чиглэлийг гарган, тэнхимийн эрхлэгч баталгаажуулан, оюутанд хүртээмжтэй болгох ажлыг зохион байгуулах шаардлагатай гэж үзлээ.
- Хичээлийн үндсэн материал нь тухайн хичээл болон багшийн ур чадвартай холбоотой учраас нэгдсэн нэг шаардлага тавих боломжгүй боловч багш бүр хичээлийн агуулгыг багцалсан материалтай байвал агуулгын баяжуулалтыг жил бүрээр харах боломж бүрдэнэ.
- Оюутны бие даалтын ажлын удирдамжууд тодорхой, ойлгомжтой боловсруулагдсан ч удирдамждаа оюутны өөрийн болон, хөндлөнгийн үнэлгээ хийх боломжийг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлага байна.
- Техник, тоног төхөөрөмжийн нөөц, боломжийг судалж, багш цахимаар сургалт зохион байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, цахим хичээлд тавигдах шаардлага хангасан хичээлийн контентын чанарт илүү анхаарч нар багш нартайгаа хамтран, цахим хичээл боловсруулах арга зүйн сургалтыг хичээлийн онцлогтой уялдуулан үе шаттай зохион байгуулан ажиллах хэрэгтэй байна.
- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагын түвшин тогтоож, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэхдээ үнэлгээний олон арга, хэлбэрийг ашиглан, тухайн хичээлээр үнэлгээний даалгаврын сан бүрдүүлсэн, үнэлгээнд ил тод, найдвартай, шударга, ижил тэгш байх зарчмыг баримталсан байгаа ч үнэлгээний даалгаврын боловсруулалт болон явцын үнэлгээний арга зүй, зохион байгуулалтыг сайжруулан, хяналт шинжилгээг өргөжүүлэх шаардлагатай гэж үзлээ.
- Хөтөлбөрийн (PLO) ба хичээлээр хүрэх үр дүн (CLO)-г жил бүр хичээлийн агуулгын шинэчлэлийг сайжруулах замаар нийцлийг хянах шаардлага байна.
- Хичээлийн чанарыг сайжруулах хүчин зүйлийн чухал хэсэг хичээлийн иж бүрдэлтэй болох нь харагдлаа.

### **Зөвлөмж**

- Хичээлийн суралцахуйн үр дүнг танин мэдэхүйн түвшнээр томъёолох
- Хичээлийн хөтөлбөрийн 1 кредит хичээлийн суралцахуйн үр дүнг баримжаалсан тоотой болох
- Хичээлийн агуулгын шинэчлэлийг багш нар жил бүр өөрийн үнэлгээ хийж, сайжруулан, тэнхимээр хэлэлцүүлэх
- Хичээл бүр сурах бичигт тавигдах шаардлагыг хангасан сурах бичигтэй байх
- Хичээл бүр үнэлгээний даалгаврын сан бүхий гарын авлагатай болох
- E-сорилын даалгаврын тавилыг сайжруулж, хэрэглэх ба задлан шинжлэх түвшний даалгаврыг оюутан өөрөө бичиж боловсруулдаг болгон өөрчлөх, гарааны болон явцын үнэлгээнд E-сорилыг ашиглах тоог нэмэгдүүлэх
- Оюутны явцын үнэлгээний ахиц, гүйцэтгэлийн үр дүнгийн судалгаагаар хичээл бүрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлгээг тогтмолжуулах
- Оюутны явцын болон эцсийн үнэлгээнд тогтмол шинжилгээ хийж, дүгнэлт гарган тэнхимээр хэлэлцэн, хэрэгжүүлэх

### **3.3. Хичээлийн чанар, багшийн арга зүйд хийсэн шинжилгээ, үр дүн, дүгнэлт**

Хичээлийн чанар, багшийн арга зүйд шинжилгээ хийхийн тулд хөтөлбөрийн баримт бичгээс арга зүйн онцлогийг шинжлэх, бодит хичээлд ажиглалт хийх, багш, оюутантай ярилцах зэрэг аргаар мэдээлэл цуглуулсан болно.

Үүний тулд 2022 оны 4, 5 дугаар сард Дорнод Их сургууль, Ховд их сургуульд тус тус 2 судлаач томилолтоор ажилласан. (Товч тайланг хавсралтад оруулав).

#### **Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудын хөтөлбөрийн арга зүйд хийсэн шинжилгээ**

Сургалтын хөтөлбөр нь тодорхой түвшний боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн боловсролын зорилго, зорилт, суралцахуйн үр дүн, хичээлийн агуулга, сурах сургах арга зүй, үнэлгээний арга зүй, орчин хэрэглэгдэхүүн тэдгээрийн хоорондын нарийн уялдаа холбоог тодорхойлсон нэгдмэл баримт бичиг юм.

Сургалтын хөтөлбөр боловсруулах нь юу заах, хэнд, хэрхэн заах зэргийг системтэйгээр зохион байгуулах үйл явц бөгөөд хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүд нэг нэгэндээ харилцан нөлөөлж байдаг. Жишээлбэл: юуг заах нь хэнд заах (тэдний нас, төлөвшил, боловсролын хөгжил)-аас шалтгаалдаг. Агуулгыг хүргэх буюу арга зүйд хэн зааж байгаа, түүний зан чанар төлөвшил, нөхцөл байдал зэрэг нь нөлөөлдөг.

Хөтөлбөр дараах шаардлагад нийцсэн байна. Үүнд:

1. Суралцахуйн үр дүн болон хөтөлбөрт тавигдах нийтлэг шалгуурыг хангасан байна.
2. Онол практикийг хослуулсан байна.
3. Суралцагсдын мэргэжлийн болон хувь хүний чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байна.
4. Сургалтын арга зүй, суралцахуйн үр дүн, сургалтын үнэлгээний хэлбэрүүдийг бүрэн хангасан байна.

Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын хөтөлбөрийн агуулга оюутан юу мэдсэн байх вэ? буюу агуулга, үзэл баримтлалын талаарх мэдлэг олгох үйлээс оюутнууд юу хийж чаддаг байх вэ? гэсэн XXI зууны иргэдийн эзэмшсэн байх шаардлагатай чадамж руу чиглэн өөрчлөгдөж байна.

Багш бэлтгэх их, дээд сургуулиуд хөтөлбөрийн агуулгатаа төгсөгчдийн эзэмшсэн байх чадамжийн жагсаалт дараах байдлаар тодорхойлох болжээ. Үүнд:

- Эргэцүүлэн бодох болон асуудал шийдвэрлэх чадвар,
- Байгалийн ухаан, математик, нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэг, урлагийн салбарын өөр өөр эрэлт хэрэгцээнд хөрвөх чадвар,
- Унших-бичих, ярих, сонсох чадваруудыг багтаасан харилцааны чадвар,
- Мэдээлэл, технологийн мэдлэг,
- Өөр өөр чиг хандлагад мэдрэмжтэй байх, тухайлбал жэндерийн асуудал, олон ургалч ардчилсан нийгэмд оролцохдоо олон соёл болон олон улсад өрсөлдөх чадвар,
- Иргэний, олон улсын, байгаль орчны үүрэг хариуцлага, оролцоо,
- Багаар ажиллах, бусадтай хамтран ажиллах зэрэг хувийн чадварууд,
- Зан байдал, ёс суртахууны төлөвшил,
- Өөр өөр эх сурвалжаас мэдлэг олж авах чадвар зэргүүд болно.

Энэ ч утгаараа хөтөлбөрийн арга зүйд шинэчлэл хийгдэх нь зүйн хэрэг юм. Сүүлийн 30 жилийн хугацаанд хөтөлбөрт хийгдсэн олон шинэчлэл, өөрчлөлтөөс гурван гол өөрчлөлтийг онцолбол:

1. Агуулгыг бүрэн эзэмшүүлэхэд голлон анхаардаг сургалтын зорилгоос чадамжийг өргөн хүрээнд эзэмшүүлэх зорилгод шилжсэн;

2. Суралцахуйн салангид хэлбэрээс хөтөлбөр хооронд шилжин сурах интеграцичилсан хэлбэрт шилжсэн;
3. Хичээлийн сэдэв нь гол гэж үздэг хэлбэрээс хөтөлбөрийн шинэчлэлийн чухал хэсэг болох сургалтын арга, үнэлгээний шинэ арга хэлбэр, санаачилгуудад шилжсэн; гэж 2017 оны “Дээд Боловсролын Шинэчлэлийн Төсөл” тайланд бичсэн байна.

Хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа зорилтот үр дүнтэй уялдах мэдлэгийн агуулга, үүнтэй уялдах идэвхтэй сургалтын арга ажиллагаа, зорилтот үр дүнд хүрсэн эсэхийг үнэлэх үнэлгээний тохирох аргыг сонгож ‘Бүтээлчээр холбох аргаар’ (Biggs & Tang, 2011) хичээлийн хөтөлбөрөө боловсруулах нь үр дүн, үйл явц, үнэлгээ гурвыг хооронд нь уялдуулсан сайн сургалтын хөтөлбөр болгож хөгжүүлэхэд тустай. Зураг 1-т бүтээлчээр холбох аргыг дүрслэн үзүүлжээ.

Зураг 1. Бүтээлчээр холбох арга Эх сурвалж: Biggs (2002)-ийн санааг буулгасан.



Дээрх судалгааны баримтууд нь сургалтын хөтөлбөр амжилттай хэрэгжихийн үндсэн нөхцөлүүдийн нэг нь арга зүй болохыг батлан харуулжээ.

Тухайн хөтөлбөрт элссэн оюутнууд хөтөлбөрөөр мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшихэд арга зүй чухал байдаг. Ийм учраас тухайн сургалтын хөтөлбөрийн онцлогт тохирсон арга зүй, хүргэх хэлбэрийг сургалтын хөтөлбөрийн баримт бичигт хавсарган, багш нарт санал болгодог жишиг байна.

Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудын хөтөлбөрийн арга зүйд шинжилгээ хийсэн үр дүнг танилцуулж байна.

Сургууль бүр стратеги төлөвлөгөөндөө “сургах ба суралцах үйл явцыг дэлхийн тэргүүлэх их, дээд сургуулиудын түвшинд хүргэнэ” гэж тодорхойлсон байна. Багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын хөтөлбөрийн арга зүйд шинжилгээ хийж үзэхэд дараах хэд хэдэн онцлог шинжүүд ажиглагдаж байна.

Үүнд:

1. Сургалтын арга зүйг боловсруулахдаа Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичгүүд болон тухайн сургуулийнхаа сургалтын журам болон зөвлөмж, шаардлагад нийцүүлдэг байна.
2. Тухайн сургуулийн журамд заасан ёс зүйн дүрэмд нийцүүлдэг.
3. Тухайн сургуулийн хөтөлбөрийн онцлогийг арга зүйдээ тусгасан.
4. Оюутны бүтээлч санаачилга, оролцоонд тулгуурладаг.
5. Сургалтын арга зүйн үр дүнд судалгаа хийж сайжруулдаг.

**Сургалтын арга зүйг боловсруулахдаа Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичгүүд болон тухайн сургуулийнхаа сургалтын журам болон зөвлөмж, шаардлагад нийцүүлдэг байна.**

Жишээлбэл, арга зүйг боловсруулахдаа дараах баримт бичгүүдийг мөрдлөг болгодог байна. Үүнд:

1. Дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх бакалаврын мэргэжлийн чиглэл/хөтөлбөр/ индекс (БШУ-ны сайдын 2014 оны 03 сарын 13-ны өдрийн А/78 тоот тушаал)
2. Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага (БШУ-ны сайдын 2014 оны 04 сарын 28-ны өдрийн А/174 тоот тушаал)

***Тухайн сургуулийн журамд заасан ёс зүйн дүрэмд нийцүүлдэг.***

Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын дагаж мөрдөх хэм хэмжээг сургуулийнхаа сургалтын журам болон дүрэмд дараах агуулгын хүрээнд оруулсан байна. Үүнд:

1. Боловсролын бодлого хэрэгжүүлэх, хөгжүүлэхэд идэвх санаачилгатай, бүтээлч, хариуцлагатай оролцох
2. Мэдлэг чадвар, заах арга барилаа байнга дээшлүүлж, сургалтын арга технологийн шинэчлэлтэд хувь нэмэр оруулах
3. Хичээлийн агуулгыг орчин үеийн нийгмийн болон салбар ухааны хөгжлийн шаардлага, чиг хандлагатай нийцүүлэн шинэчилж байх
4. Хичээлийн хуваарь, цагийг баримтлах
5. Суралцагчтай ажиллах, зөвлөгөө өгөх хуваарийг баримтлах
6. Хичээлийн цагийг үр өгөөж, идэвхтэй өнгөрүүлэх
7. Суралцагчдад хичээл, сургалттай холбогдолтой мэдээ, мэдээлэл олж авах боломж бүрдүүлэх
8. Суралцагчийн эрдэм номд хандах идэвх санаачилгыг өрнүүлэх, бие даан суралцах чадвар эзэмшүүлэх, бүтээлч, шүүмжлэлт, логик сэтгэлгээг хөгжүүлэх
9. Суралцагчийн мэдлэг, чадварыг шалгах хэлбэр, шалгалтын агуулгын хүрээ, үнэлэх шалгуурыг ил тод, тодорхой байлгах
10. Суралцагчийн даалгаврыг цаг тухайд нь шалгаж үр дүнг мэдээлж байх
11. Суралцагчийг шалгах, дүгнэх, үнэлэх, ажил удирдах, тодорхойлолт бичихдээ тэгш, шударга, бодитой хандах
12. Суралцагчийн бие даан гүйцэтгэх ажил нь оюутны боломж, хөтөлбөрийн түвшинд нийцсэн байж, тухайн ажлын чиглэл, агуулга, ашиглах мэдээллийн эх сурвалжийг тодорхой байлгах

***Хориглосон хэм хэмжээ:***

1. Хичээл таслах, хичээлээс хоцрох, эрт тараах, хичээлийн цагаар танхимыг орхих
2. Дүнг бодитой бус, хуурамчаар тавих
3. Зохих журмаар батлагдсан хичээлийн хөтөлбөр, бусдын судалгааны чиглэлийг үгүйсгэж, тэдгээрт итгэх суралцагчийн итгэлийг хөсөрдүүлэх
4. Суралцагчдад бие даан сурах хэрэглэгдэхүүн, хичээлийн гарын авлага, ном, сурах бичиг тулган борлуулах
5. Суралцагчийн сурлагад ахиц гарахад саад болох

***Тухайн сургуулийн хөтөлбөрийн онцлогийг арга зүйдээ тусгасан.***

Багш бэлтгэх хөтөлбөр хэрэгжүүлж байгаа тухайн сургуулийн бүтээсэн соёл, туршлага нь арга зүйн өвөрмөц онцлогуудыг тусгасан байна. Жишээлбэл:

- Соёл урлагийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг буюу “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалтын байгууллага нь дэлхийн сонгодог бүжгийн арга зүйг үндэсний бүжгийн арга зүйтэй хослуулсан орчин үеийн арга зүй;

- Шинжлэх ухааны чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг буюу “Багш, байгалийн ухааны боловсрол” хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалтын байгууллага нь орчин үеийн техник технологийн дэвшил бүхий лабораторид суурилсан арга зүй;
- Хүмүүнлэгийн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг буюу “Багш, гадаад хэлний боловсрол” хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалтын байгууллага нь оюутны оролцоог чухалчилсан клуб, сайн дурын бүлгүүдийг дэмжсэн арга зүй;
- Хөдөө орон нутагт “Багш, боловсрол” хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалтын байгууллага нь орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ЕБС-тай хамтран ажиллах арга зүй;
- “Багш, боловсрол” чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулж буй сургалтын байгууллага нь гадаад, дотоодын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллах арга зүй;

**Оюутны бүтээлч санаачилга, оролцоонд тулгуурладаг.**

Хөтөлбөр бүрд байгаа нэг нийтлэг зүйл бол сэтгэхүйн үйлийг хөгжүүлэх, сурах болон судалгаа шинжилгээний арга барилд сургах, суралцагч буюу оюутан төвтэй арга зүйг онцолдог гэсэн 3 санааг чухалчлан үзсэн байна. Жишээлбэл: “Оюутны бүтээлч идэвх санаачилга, оролцоонд тулгуурлан асуудлыг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулах, бүтээлчээр шүүмжлэх, гол ба туслах хэсгүүдэд ялгаж, нийтлэг чанарыг олж тогтоох зэрэг сэтгэхүйн үйлдлийг хөгжүүлнэ. Мөн үзэл бодлоо харилцан солилцох, өөрийн үзэл бодлыг үндэслэлтэйгээр хамгаалах, мэтгэлцэх, хамтран ажиллах, хамтын үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, судалгаа шинжилгээний арга барилд сургана. Иймд хичээлд оролцооны арга зонхилох ба сургалтын идэвхтэй болон интерактив зэрэг оюутан төвтэй арга зүйг түлхүү хэрэглэдэг.” гэж хөтөлбөрүүдэд тусгасан байна.

**Сургалтын арга зүйн үр дүнд судалгаа хийж сайжруулдаг.**

Багш нарын заах аргын ур чадварыг сайжруулахын тулд хөтөлбөрийн нэгж багшийн хичээлд ажиглалт хийх, сургалтын арга зүйн үр дүнд судалгаа, анализ хийж ажилладаг.

Хүснэгт 1. Оюутнаас авсан судалгааны үр дүн

№	Асуулт	Дундаж оноо
	<b>Багшийн заах арга зүйн талаар</b>	
1	Багш хичээлийг логик дэс дараалалтай, сонирхолтой, ойлгомжтой заадаг	2.6
2	Багш оюутны оролцоог нэмэгдүүлэх арга зүй сайтай	2.6
3	Багш оюутнуудад бичиж тэмдэглэх боломжтойгоор сургалтаа явуулдаг	2.7
4	Багшийн зааж буй хичээл тухайн / Сургалтын удирдлага мэдээллийн системд буй/ хичээлийн хөтөлбөртэй нийцдэг	2.7
5	Багш И-сургалтын арга, хэрэгсэл ашигладаг, хичээл сургалтын материалаа онлайнд байршуулдаг, оюутанд хүртээмжтэй өгдөг	2.6
6	Хичээл хөтөлбөрт тусгагдсан агуулгын дагуу явагддаг	2.8
7	Оюутны бие дааж сэтгэн бодох, таамаглах, логик дүгнэлт гаргахад нь тусалдаг	2.6
8	Багшийн өгсөн даалгаврын зорилго, агуулга, түвшин, зарцуулах цаг нь тохирсон байдаг	2.6
9	Багш хичээлийн бус цагаар тогтсон хуваарийн дагуу оюутанд зөвлөгөө өгөх, мөн оюутны бие даан суралцах, өөрийгөө илэрхийлэх чадварыг хөгжүүлэхэд анхаардаг.	2.6

	<b>Багшийн харилцаа, ёс суртахууны талаар</b>	
1	Багш оюутныг хүндэтгэн соёлтой харьцаж, санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх уур амьсгалыг бүрдүүлдэг	<b>2.7</b>
2	Багш хувь хүний төлөвшил, хүмүүжлийн тал дээр оюутанд үлгэрлэж чаддаг	<b>2.6</b>
3	Багш хичээлийн цагийг үр бүтээлтэй, бүрэн ашигладаг	<b>2.7</b>
	<b>Оюутны сэтгэл ханамж</b>	
1	Энэ хичээл надад сонирхолтой санагдсан	<b>2.6</b>
2	Дараагийн улиралд энэ багш өөр хичээл заасан тохиолдолд дахин сонгоно.	<b>2.6</b>
3	Оюутнууд энэ хичээлээр ямар мэдлэг, чадвар эзэмшсэнээ сайн мэднэ.	<b>2.7</b>
4	Энэ хичээл хөтөлбөрт заагдсаны дагуу оюутны суралцах зорилгыг хангаж чадсан	<b>2.6</b>

Түүнчлэн оюутны дидактикийн мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх талаас анхаарч, тодорхой арга, лекц, семинарын хичээлийн хэлбэр, багш нарын хэрэглэдэг аргуудыг тоочиж жагсаан бичсэн байна.

## 1. Тодорхой арга

- Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх
- Интерактив сургалт
- Төсөлт ба инновац сургалт
- Дүрт тоглоомын арга
- Кейс сургалт
- Мультимедиа сургалт

## 2. Лекц, семинарын хичээлийн хэлбэр

*Хүснэгт 2. Сургалтын аргууд*

Лекцийн хичээлд	Уламжлалт лекц Видео, аудио контентод тулгуурласан лекц Хэлэлцүүлэг, асуудал дэвшүүлэн хэлэлцэх лекц Тодорхой тохиолдол, эх сурвалжид тулгуурласан лекц Судлан хэлэлцэх лекц
Семинарын хичээлд	Хэлэлцүүлэг Мэтгэлцээн Видео, нэвтрүүлэг, кино, контент түшиглэсэн ярилцлага Асуудал шийдвэрлэх Баримт бичиг судлах Тодорхой тохиолдолд дүн шинжилгээ хийх Бодлого, дасгал ажиллах Дүрд тоглох Эссэ бичиж хэлэлцэх Оюуны зураглал хийх Загасан нуруу хийх (шалтгаан, үр дагаврын шинжилгээ хийх) Судалгааны илтгэл хэлэлцэх Төсөлт ажил гүйцэтгэх, тайлагнах

### 3. Багш нарын хэрэглэдэг аргууд

Хүснэгт 3. Сургалтын аргууд

№	Лекц	Семинар	Дадлага
1	Тонгоруу арга	Бүтээлч сэтгэлгээний арга	Даалгаварт тулгуурласан сургалтын арга
2	Холимог сургалтын арга	Даалгаварт тулгуурласан сургалтын арга	Идэвхтэй сургалтын арга
3	Харилцааны арга	Идэвхтэй сургалтын арга	Аудио визуал арга
4	Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх арга	Харилцааны арга	Харилцааны арга
5	Бүтээлч сэтгэлгээний арга	Асуудал дэвшүүлэн шийдвэрлэх арга	TPR
	Бусад аргачлал	Бусад аргачлал	Бусад аргачлал
6	Хэлэлцүүлэг	KWL	Тоглоомын арга
7	Оюуны зураглал	Тархины шуурга /санаа цуглуулах/	Мэдээлэл солилцох
8	Асуулт хариулт	Мэдээлэл солилцох	Ангид судалгаа явуулах
9	Зураг тайлбарлах	Venn diagram	Дүрт тоглоом
10	Мультимедиа	Хэлэлцүүлэг	Цасан бөмбөлөг
11	Ярилцлага	Тодорхой тохиолдол судлах	Өгүүллэг, түүх зохиох
12	Мэтгэлцээн	Тулгуур дохионы арга	Тоглоомын арга
13	Аудио, видео контент хэрэглэх	Эвлүүлгийн арга	Тодорхой тохиолдол судлах арга
14	Лекцийн гол хэсгийг дүгнэж бичих аргачлал	Илтгэл тавих	Интерактив
15	Тодорхой тохиолдол судлах	Оюуны зураглал хийх	Эдьютэйнмент
16	Булингартай хэсэг аргачлал	Асуулт хариултын арга	Жишээн дээр суурилсан арга
17	15 минутын бичлэг	Инсерт арга	Эвлүүлгийн арга
18		Ангид судалгаа явуулах	
19		Сократын асуулт	
20		Мэтгэлцээн	

### 4. Танхимын сургалтад хэрэглэж буй сургалтын аргууд

№	Сургалтын арга	Хичээлийн хэлбэр			Нийт
		Лекц	Семинар	Лаб	
1.	Багаар ажиллуулах	3	13	8	24
2.	Багийн хэлэлцүүлэг	4	11	4	19
3.	Хосоор ажиллах	3	8	5	16
4.	Ганцаарчлан ажиллах	3	7	4	14
5.	Галерей үзэх/Сурталчлах	0	8	2	10
6.	Асуулт тавих/боловсруулах	4	1	4	9
7.	Мини тийчинг/Багшлах/Мок хичээл	0	6	2	8
8.	Самбарт ажиллуулах	0	2	2	4
9.	Даалгаврын анализ багаар хийх	0	3	0	3
10.	Нэг нь үлдэж бусад нь явах	0	3	0	3

11.	Хоёр од нэг хүсэл	1	1	0	2
12.	Үзэл бодлоо уралдуулах	1	1	0	2
13.	Элчин сайдын өртөө	0	1	0	1
14.	Гарах виз	0	1	0	1
15.	Наймаалцах	0	1	0	1

Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудын зарим хөтөлбөрийн арга зүйд дараах үнэлгээний шалгуурын дагуу анализ хийлээ.

### Хичээлийн арга зүйд үнэлгээ хийх хуудас

№	Үзүүлэлт	Авах оноо	Авсан оноо	Гүйцэтгэлийн хувь
1.	Нэгдүгээр курсийн оюутнуудын суралцахуйг дэмжсэн үйл ажиллагааг тусгасан эсэх	25	5	20%
2.	Оюутнууд баг болон группүүдэд хуваагдаж ажиллах арга зүй тодорхой эсэх	25	20	80%
3.	Оюутнуудын бичих ур чадвар буюу мэдээлэл боловсруулах үйлийг дэмжсэн эрчимжүүлсэн сургалт зохион байгуулдаг эсэх	25	10	80%
4.	Хамтран суралцах буюу төсөл, судалгаа хийх арга зүй тодорхой эсэх	25	18	72%
5.	Оюутны ялгаатай байдлыг харгалзан үзэж, тохируулга хийдэг эсэх	25	5	20%
6.	Нийгмийн сайн сайхны төлөөх ажилд оролцож, асуудлыг шийдвэрлэж, өөрийгөө хөгжүүлэх боломжтой эсэх	25	15	60%
7.	Бодит орчинд дадлага хийх боломжийг олгосон арга зүйг тодорхойлсон эсэх	25	20	80%
8.	Төгсөлтийн ажил бичих арга зүйг тодорхойлсон эсэх	25	22	88%
9.	Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарт дэмжлэг үзүүлэх ажлын хуудас	25	5	20%
10.	Насан хүрэгчид буюу залуучуудтай ажиллах, тэдний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зөвлөмж	25	7	28%
Бүгд		250	127	50.8%

Багш мэргэжилтэн бэлтгэдэг дэлхийн их дээд сургуулиуд хөтөлбөртөө дээрх шалгууруудыг оруулж өгсөн байдаг. Судалгааны үр дүнгээс харахад хөтөлбөрүүдэд байгаа нийтлэг алдаа бол тухайн курсийн оюутнуудад чиглэсэн тодорхой арга зүй, оюутны ялгаатай байдлыг харгалзан үзэх арга зүй, хөтөлбөр хэрэгжүүлэх багш нарт дэмжлэг үзүүлэх тодорхой арга, аргачлалыг тусгаж өгөөгүй байна. Бүх сургуулиуд “оюутан төвтэй арга зүйг эрхэмлэнэ” гэж бичсэн боловч, түүнийг бүрэн гүйцэт томъёолоогүй. Хөтөлбөр бүрд өөрийн гэсэн давуу тал, сайн туршлага байгаа боловч аргуудын жагсаалт, тайлбар, тайлан шинжтэй болсон байгааг цаашид анхаарч, хөгжүүлэх хэрэгтэй байна. Хөтөлбөрийн арга зүй нь багш, суралцагч хоёрыг агуулгатай нь холбох гүүр байдаг. Өөрөөр хэлбэл, агуулгыг хэрэгжүүлэх арга зүйг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулсан арга зүйн цогц баримт бичгийг боловсруулах нь багш бэлтгэдэг их дээд сургуулиудын шийдэх асуудал болсон байна.



## 5. Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нараас авсан арга зүйн судалгаа

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн шинэчлэлийн асуудлаар багш нараас асуулгын судалгаа авсан. Судалгааны үр дүнгээс харвал:

- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэдэг (100% тийм гэж хариулсан) гэж багш нар үзжээ.
- Сургалтын арга зүйн үр дүнд судалгаа хийж сайжруулдаг уу? гэсэн асуултад 25 багшаас 3 нь үгүй, 22 нь тийм гэж хариулсан.
- Багш нарын 92% нь сургалтын тэгш, хүртээмжтэй арга зүйд суралцдаг байна.
- Цахим болон онлайн хичээлд Тонгоруу сургалтын аргыг хэрэгжүүлж буй багш 60%-ийг эзэлж байна.
- Нийт багш (100%) сургалтын арга зүй зарчим нь сонголт хийх, боломж олгох, бие даан суралцах нөхцөлийг хангасан гэж үзжээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын сургалтад хэрэглэж буй аргуудыг судалж үзсэн. Сургалтын онцлогоос шалтгаалан лекц, семинар, лабораторийн болон практик хичээлд ашиглаж буй аргууд ялгаатай байна.

Та өөрийн хэрэглэдэг сургалтын аргуудаас голлох 3-5 аргыг бичнэ үү? Ямар аргыг, оюутны ямар чадварыг хөгжүүлэхэд ашигладаг вэ? гэсэн судалгааны асуултад хариулсан байдлыг болон зарим багшийн боловсруулсан хичээлийн хөтөлбөрт тусгагдсан сургалтын аргуудыг нэгтгэж, хүснэгт 4-д үзүүлэв.

Хүснэгт 4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд голлон ашиглаж буй сургалтын аргууд

Хич/ хэлбэр	Багш нараас (n=25) авсан судалгаанд		Хичээлийн хөтөлбөрт (n=10)	
	нэрлэсэн аргууд	давтамж	тусгасан аргууд	давтамж
Лекц	Асуудал шийдвэрлэх	3	Асуудал дэвшүүлсэн лекц	7
	Асуулт асуух	3	Дүн шинжилгээ хийх	7
	Тайлбарлах	6	Тайлбарт лекц	43
	Жишээгээр тайлбарлах	3	Санаагаа зураглая	2
			Харилцан ярилцах	12
			Ярилцах боломж олгох арга	3
			Үзүүлэн таниулах	19
			Визуаль лекц, Жагсаах	2
			Бүтэцчилсэн танилцуулга	3
			Бага хурлын арга	2
			Хамтран сонсох, Бингодох	2+1
			Марафон уншлага	1
			Бүтээлч тэмдэглэгээ	6
			Тодорхойлолт гаргах	1
			Товч бичиглэл хийх	2
	Семинар, Лаборатори			Эргэцүүлэн дүгнэх
			Завсрын түр зогсолттой лекц	1
			Кейс анализ	1
			Нэгтгэн дүгнэх	2
Сорилын хариултыг шинжлэх		1	Мэдээлэл хайж олох, солилцох, багцлах	10
Мэдлэг бүтээх		2	Мэтгэлцэх	2
Багаар ажиллах	2	Багаар ажиллах	29	
KWL	1	Загварчилсан тэмдэглэл	10	

	Хосоор ажиллах	1	Хосоор ажиллах	2
	Харилцан ярилцах	4	Харилцан ярилцах	73
	Гардан үйлдэл	1	Шуурхай хариулт	5
	Хэмжилт хийх	1	Хэмжилт хийх	4
	Венийн диаграмм	1	Бүтээлч тэмдэглэгээний арга	25
	Бүтэцчилсэн танилцуулга хийх		Бүтээлч эргэцүүлэл	2
	Блиц хариулт	1	Үзүүлэн таниулах	25
	Кейс судалгаа хийх	1	Солилцооны арга	9
	Үзүүлэн хийх, бүтээх	1	Багаар судалгаа хийх	1
	Хэлэлцүүлэг	1	Тайлбарлах	33
	Үнэлгээ өгөх, дүгнэлт гаргах	5	Хэлэлцүүлэг	21
	Бодит байдлыг үзэх аялал	3	Үнэлгээ өгөх	4
		1	Дадлага ажил	18
			Дүгнэн ярих	6
			Эхтэй ажиллах	6
			Мэдээллийг нэгтгэн багцлах	1
			Дүрд тоглох	4
			Эргэцүүлэн дүгнэх	4
			Марофон бичлэг, уншлага	3
			Тойрч яв, тодруулж ярилц	1
			Онолын хураангуй хийх	1
			Карт тохируулах, эвлүүлэг	1+2
			Зураглал, бүдүүвч зурах	5
			Булангийн арга	1
			Бүтээлч даалгаврын арга	1
			Бүтээлд шинжилгээ хийх	1
			Задлан шинжлэх	15
			Тохиолдлыг шинжлэх	4
			Асуултын хана бэлтгэх	1
			Бодол санааны өрнөлт	1
			Бие биедээ зөвлөгөө өгөх	4
			Фиширын арга	1
			Тооцоолох, хүснэгтлэн ялгах	9+1
Практик	Биеэр үзүүлэх	8	Биеэр үзүүлэх	38
	Жишиж харьцуулах	3	Техникийг жиших	12
	Тоглоомын арга	3	Тоглоомын арга	8
	Дагуулж ба дуурайх	3	Дагуулж ба дуурайх	2
	Давтах	6	Давтах	55
	Ялгаатай ачаалал өгөх	1	Ялгаатай ачаалал өгөх	2
	Бусдад заах	4	Зургаар үзүүлэх	12
	Дасгал зохиомжлох	1	Мэргэжлийн багаж хэрэгсэл ашиглах	2
			Давтан сайжруулах	9
			Тайлбарлах	37
			Хөөж гүйх	1
			Харилцан ярих	9
			Үнэлгээ өгөх	6
			Тэмцээний арга	5
			Тойргийн бэлтгэл	14
			Хувьсган өөрчилж давтах	7
			Завсарлагагүй хувиргах	1
		Хөдөлгөөнөөр дүрслэх	14	
		Дүрд тоглох	3	
		Хөдөлгөөнийг холбох арга	3	

		Дуут дохионы арга	4
--	--	-------------------	---

Хүснэгт 5. Лекцийн хичээлийн зураглал

<b>Бэлтгэл үе</b> Тухайн сэдвийн хүрээнд агуулга, арга зүйг төлөвлөх	<b>Хэрэгжүүлэх үе</b> Хөтөлбөрийн дагуу лекцийн хичээлийг зохион байгуулах	<b>Сайжруулах, үнэлгээ хийх</b> Хөтөлбөрийн хэрэгжилтэд дүгнэлт хийх, сайжруулах
---	---	---

**Лекцийн хичээлд суусан ажиглагчийн тэмдэглэл.**

**Лекцийн 1 дүгээр хэсэг**

1. Лекцийг УМС дээр 7 хоногийн өмнө байрлуулах
2. Оюутнууд багшийн чиглүүлгийн дагуу агуулгыг судалж, холбогдох ном зохиол, эх сурвалжуудыг уншиж судлах

**Лекцийн 2 дугаар хэсэг**


№	Үйл ажиллагаа	Үр дүн
1	<i>Түлхүүр үгийн утгыг оюутнуудад тайлбарласан.</i>	<i>Мэргэжлийн эх буюу текстийг унших боломжийг бүрдүүлсэн.</i>
2	<i>Багш, онолын асуудлыг дэвшүүлж бичсэн мэргэжлийн текст буюу эхийн мэргэжлийн үг хэллэгийг тайлбарлаж, оюутнуудтай хамтарч уншсан. (Арга зүй нь: Мэргэжлийн текст буюу эхийг, нэр томъёог тайлбарлах аргаар унших)</i>	<i>Оюутнууд онолын тулгуур ойлголт авсан.</i>
3	<i>Тулгуур ойлголтыг өгсний дараа, оюутнууд УМС дээрээс уншсан мэдлэг, ойлголт, туршлага дээрээ тулгуурлан онолыг жишээгээр баталж тайлбарласан. (Арга зүй нь: Оюутан өмнөх мэдлэг туршлага дээрээ тулгуурлан, мэдлэгээ хэрэглээ болгох)</i>	<i>Оюутнууд мэдлэг, ойлголтоо хэрэглээ болгох үйлийн баримжаатай болсон.</i>
4	<i>Багш асуудал дэвшүүлсэн даалгаврыг оюутнуудад өгсөн. Оюутнууд онолын мэдлэгээ ашиглаж, асуудал дэвшүүлсэн даалгаврыг гүйцэтгэсэн.</i>	<i>Асуудалтай нөхцөл байдлын тэмдэгт загварыг үйлийн мета түвшинд төлөвлөх, хянах, үнэлэх үйлийг гүйцэтгэсэн. Асуудлыг шийдвэрлэхдээ урт хугацааны ой санамжид байгаа мэдлэг туршлагаа ашигласан.</i>
5	<i>Онолын мэдлэгээ хэрэглээ болгоход анхаарч семинарын хичээлийн агуулгыг танилцуулсан.</i>	<i>Оюутнууд семинарын хичээлийн агуулга, хийх үйлийн зорилгоо ухаарсан.</i>
<b>Цаашид анхаарах зүйл</b>		
<i>Хичээлийн төгсгөлд багш, оюутнуудаас тодруулах асуулт байгаа эсэхийг асуусан. Нэг ч оюутан асуугаагүй. Эргэлзсэн, тодруулах шаардлагатай зүйлээ тэмдэглэл хөтлөх явцдаа тодруулсан бичдэг стратегийг эзэмшихэд багш, оюутнууд анхаарах.</i>		

Хүснэгт 6. Семинарын хичээлийн зураглал


<b>Бэлтгэл үе</b>	<b>Хэрэгжүүлэх үе</b>	<b>Сайжруулах, үнэлгээ хийх</b>
-------------------	-----------------------	---------------------------------

Тухайн сэдвийн хүрээнд агуулга, арга зүйг төлөвлөх	Хөтөлбөрийн дагуу семинарын хичээлийг зохион байгуулах	Хөтөлбөрийн хэрэгжилтэд дүгнэлт хийх, сайжруулах
--	--	--

### Семинарын хичээлд суусан ажиглагчийн тэмдэглэл

№	Үйл ажиллагаа	Үр дүн
1	Оюутнууд сэтгэл судлалын лекцийн агуулгын хүрээнд цахим танилцуулга бэлтгэж ирсэн. Түүнийг багийн нэг гишүүн нь танилцуулсан.	Оюутнууд цахим танилцуулгыг бэлтгэхийн тулд лекцийн агуулгаа судалж, мэдлэгээ бататгасан.
2	Лекцийн агуулгын хүрээнд багаараа цэцэрлэгийг 1 бүлгийг судалж, түүний үр дүнг танилцууллаа.	Багаар ажиллах чадвараа хөгжүүлсэн. Судалгааны арга барилд суралцсан. Мэдлэгээ хэрэглээ болгосон.
3	Өнөөдрийн семинарын хүрээнд унших материалыг багш багуудад агуулга тус бүрээр нь хувааж өгсөн. Багш-агуулгын загварчилсан мэдээллийг танилцуулсан. Тухайн хэсгийг судалсан багийн гишүүд нэмэлт мэдээллийг бусдадаа хүргэсэн.	Агуулгыг багш, оюутнууд хамтдаа бүтээсэн. Оюутны бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн.
4		
5	<p>Хичээл заасан багшийн сэтгэгдэл:  <i>Орчин цагийн оюутан залуучуудын хувьд техник технологиор дамжуулан мэдээллийг хүлээж авах сонирхол нь илүү байдаг. Иймд тухайн сэдвийн хүрээнд багаараа хамтарч цахим контент хийх даалгаврыг өгсөн. Энэ нь тэднийг идэвхжүүлэх нэг арга юм. Зүгээр номоо уншаад тэмдэглэл хөтлөөд ир гэх нь шинэ цагийн оюутнуудад тохирох арга зүй биш. Хичээлийг техник технологийн дэвшлийг ашиглан интерактив аргаар зохион байгуулах хэрэгтэй.</i></p>	

Зураг 2. Семинар болон лекцийн хичээл





### Дүгнэлт

- Багш бэлтгэдэг их, дээд сургуулиуд хөтөлбөрийн арга зүйг боловсруулахдаа хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагын дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичгүүд, тухайн сургуулийнхаа сургалтын журам болон зөвлөмжийг үндэслэл болгодог.
- Хөтөлбөрийн арга зүйн хэсэгт суралцагч буюу оюутан төвтэй арга зүйг чухалчилдаг болохыг тайлбарлан, идэвхтэй сургалтын аргуудыг тоочсон.
- Багшийн заах арга, ур чадварыг сайжруулахын тулд хичээлд ажиглалт хийж, үр дүнг боловсруулж, оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг.
- Багш нар хөтөлбөрийн дагуу хичээлийг зохион байгуулахдаа оюутны оролцоог чухалчилж байна.
- Техник технологийн дэвшил+сургалтын интерактив арга гэсэн бүтэц бүхий семинарын хичээлийн соёл хөгжиж байна.

### Зөвлөмж

- Сургалтын хөтөлбөрийн арга зүйг боловсруулахдаа тухайн хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлэхэд чиглэсэн буюу суралцахуйн үр дүнг эзэмшихэд туслах, чиглүүлэх үйл ажиллагаа (суралцах туршлага)-г тодорхой төлөвлөх.
- Тухайн хөтөлбөрийн онцлогт нийцсэн арга зүй буюу үйл ажиллагааг төлөвлөх.
- Арга зүй буюу үйл ажиллагааны төрлүүдийн жагсаалтыг тайлбартай нь хамт төлөвлөх.
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарт зориулсан арга зүй буюу үйл ажиллагааны дизайнчилсан ажлын хуудаснууд төлөвлөх.
- Насан хүрэгчид буюу залуучуудтай ажиллах, тэдний тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зөвлөмжүүдийг хавсралтаар оруулах.

### Ашигласан материал

1. Jean-Guy, Vienneau, A, Амарзаяа. (2017). ДБСБ-уудын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, хэрэгжүүлэх үйл явц, төслийн тайлан
2. Орхон, Б. (2018). Дээд боловсролын сургалтын хөтөлбөрийн тухай ойлголтыг тодруулах нь. *Дээд боловсрол. 01*
3. Biggs, J and Tang, C. (2011). *Teaching for Quality Learning at University*. New York: SRHE
4. Магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр.



### **3.4. Хандлага, сэтгэл ханамжийн судалгаа, үр дүн, дүгнэлт**

Хандлага, сэтгэл ханамжийн судалгаа хийхийн тулд багш, төгсөгч, суралцагчдын төлөөллөөс авах асуулга (Хавсралт №2) боловсруулж, тодорхой тооны төлөөллөөс авч нэгтгэсэн болно.

#### **Санал асуулгын үр дүн**

Санал асуулгыг хөтөлбөр хэрэгжүүлэгч багш, хөтөлбөрийн төгсөгч, суралцагч оюутнуудаас хөтөлбөрийн чанарын талаарх сэтгэл ханамж, мэдээллийг цуглуулахаар төлөвлөсөн. Санал асуулгын асуулт бүр хаалттай байдлаар боловсруулагдсан ба асуулт бүрийн дараа нээлттэй асуултаар оролцогчийн нэмэлт санал, мэдээллийг авахыг зорьсон. Асуулга бүр ерөнхий мэдээлэл, хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчин, багшлах боловсон хүчний талаар оролцогч тал өөрийн үнэлгээг өгөх боломж бүрдсэн. Үүгээр хөтөлбөрийн хэрэгжилт, сургалтын орчин, боловсон хүчний чанар, багшлах, үйлчлэх ур чадварын талаарх оролцогчдын сэтгэл ханамжийн үнэлгээг харьцуулах боломжтой.

##### **1. Хөтөлбөрийн чанар**

- Их сургуулийн бодлого
- Сургалтын төлөвлөгөөний хичээл, тэдгээрийн агуулга, уялдаа холбоо
- Оюутны эзэмшиж буй мэдлэг, чадвар
- Үнэлгээ
- Багшлах дадлагын чанар, уялдаа холбоо

##### **2. Сургалтын орчин**

- Анги танхимын орчин
- Номын сан
- Интернет орчин
- Техник тоног төхөөрөмж
- Онлайн хичээлийн нөөц

##### **3. Багшлах боловсон хүчин**

- Багшийн хүрэлцээ
- Багшийн мэргэшсэн байдал, багшлах ур чадвар
- Багшийн харилцаа
- Багшийн оюутны дэмжиж буй байдал
- Багшийн эрдэм шинжилгээний чадвар гэсэн мэдээллийг харах боломжтой.

Сэтгэл ханамжийн судалгааг



- Багшлах боловсон хүчний төлөөлөл
- Төгсөгчдийн төлөөлөл
- Оюутны төлөөллөөс авахаас онлайн санал асуулгыг Google Form дээр асуулга боловсруулан авлаа.

Төлөөлөл тус бүрийн үр дүнг тус тусад нь авч үзье.

##### **1. Багшлах боловсон хүчин**

###### **а) Ерөнхий мэдээлэл**

Судалгаанд МУБИС, Отгонтэнгэр ИС, Хүмүүнлэгийн ИС-ийн нийт 41 багшийн 33 эмэгтэй, 8 эрэгтэй багш байлаа. Тэдний нас болон боловсролын салбарт ажилласан жилийг графикаар харууллаа.




#### b) Хөтөлбөрийн чанар

Сургуулийнхаа хэрэгжүүлж буй “багш” хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт ямар үнэлгээ өгөх вэ? гэсэн асуултад 30 багш буюу 73.2% нь хангалттай сайн гэсэн өгсөн бол 31 багш буюу 75.6% нь хичээлийн агуулга нь орчин үеийн шинжлэх ухааны түвшинд тохирч байгаа, сургалтын төлөвлөгөөний хичээлүүдийн уялдаа сайн гэж үнэлсэн байна. Сургалтын төлөвлөгөө дэх хичээлүүдийн чанар дээр багш нар сэтгэл хангалуун байдаг багш нарын тоо харьцангуй бага буюу 68.3% байна. Харин сургалтын төлөвлөгөө дэх хичээлүүд оновчтой эсэх дээр 27 багш буюу 65.9% нь санал нийлдэг байхад 25 багш буюу 61% нь ерөнхий суурь, багш мэргэжлийн суурь болон мэргэжлийн хичээлүүдийн харьцаа оновчтой болсон гэж үзжээ. Оюутныг үнэлэх үнэлгээндээ юу гол болгодог вэ гэсэн асуултад 22 багш буюу 62.9% нь оюутны мэдлэг, чадвар, хандлагыг гол болгодог ба одоогийн үнэлгээний хэлбэрээ илүү бодитой, нээлттэй болгож (14.3%), оюутны бүтээлээр үнэлэх (17.1%) саналыг дэвшүүлж, хөтөлбөрийн үнэлгээний чанарыг 73.2% нь хангалттай сайн гэж үнэлсэн байна. Оюутнуудын багшлах дадлагын залгамж холбоо хангалттай сайн (85.4%), хангалттай үр дүнтэй (87.8%) гэж дүгнэжээ.

#### c) Сургалтын орчин

Сургалтын орчныг анги танхим-суралцах орчны тохижилт, номын хүртээмж-номын сангийн үйлчилгээ, интернэт-техник тоног төхөөрөмж гэсэн 3 шалгуураар судалсан үр дүнг дараах графикаар харууллаа.





Эндээс харахад анги танхим-суралцах орчны тохижилт харьцангуй өндөр үнэлгээтэй байгаа ч орчин цагийн их сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарын үзүүлэлт болох интернэт-техник, тоног төхөөрөмжийн хангамж доогуур үнэлгээтэй байна. Сургалтын орчны талаар өгөх нэмэлт санал дээр багш нар оюутанд ээлтэй орчин бүрдүүлэх саналыг судалгаанд хамрагдсан багш нарын 25.6% нь өгсөн бол, техник тоног төхөөрөмжийг сайжруулах саналыг 20.5% нь өгсөн байгаагаас техник тоног төхөөрөмжийг сайжруулах шаардлага тулгамдаж байгааг илтгэж байна.

#### *d) Багшлах боловсон хүчин*

Хөтөлбөрийн чанарт нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг багшийн хүртээмжийг судалгаанд хамрагдсан багш нарын 29 нь буюу 70.7% нь хангалттай гэж үзсэн бол 13.3% нь эрдмийн зэрэгтэй багш нар дутагдалтай байгаа гэж үзжээ. Харин мэргэжлийн мэдлэг чадварын түвшнийг судалгаанд хамрагдсан багш нь 43.9% нь л хангалттай, ажлын байран дээрээ хөгжиж байгаа байдлыг 68.3% нь хангалттай буюу боломжийн, багш нарын ажлын ачааллыг 53.7% нь боломжийн гэж үзсэн бол 19.5% нь их гэж үзсэн байна. Энэ нь өөрсдийн заадаг хичээлийн цагийг боломжийн гэж үзсэн багш 82.9%-ийг эзэлж байгаагаас мөн харагдаж байна. Багшийн оюутантай ажиллах боломжийг 80.5% нь боломжийн гэж үнэлсэн бол эрдэм шинжилгээний ажлын ачааллыг 56.1% нь боломжийн гэж үзжээ. Харин багшийн мэргэжлийн ёс зүй, харилцааны соёлыг 75.6% нь боломжийн буюу хангалттай гэж үзсэн байхад 24.4% нь жигд биш гэж үнэлсэн байна.

## **2. Төгсөгчид**

#### *a) Ерөнхий мэдээлэл*

Магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэх хөтөлбөрийн үнэлгээний судалгаанд 2020 оноос хойш төгссөн 43 төгсөгчид хамрагдсанаас 4 төгсөгч магистрт суралцаж, мэргэжлийн зэргээ дээшлүүлж байна. Судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 81.4% нь эзэмшсэн мэргэжилдээ сэтгэл хангалуун байдаг бол 51.2% нь өнөөгийн багш мэргэжлийн нэр хүнд дунд, 30.2% нь муу гэж үнэлсэн байна.

#### *b) Хөтөлбөрийн чанар*


Төгсөгчдийн 30.2% нь эзэмшсэн мэргэжлээ хөрвөх боломжтой, 32.7% нь оюутан байхдаа эзэмшсэн хувь хүний чадварууд нь ажлын байран дээр хэрэг болж байгаа гэж үзжээ. Суралцаж байх үеийн хөтөлбөрийн бодлого хэр нээлттэй, ойлгомжтой байсныг а. элсэлтийн бодлого, б. үнэлгээний бодлого, в. сургалтын бодлого, г. хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх бодлого гэсэн шалгуураар судалж үзэхэд судалгаанд оролцогчдын 44.2% - 58.14% нь элсэлтийн, үнэлгээний, сургалтын бодлогыг тодорхой гэж дүгнэсэн бол 32.6% нь л хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх бодлогыг тодорхой, 30.2% нь тодорхойгүй гэж үнэлсэн байна.

Хичээлийн хөтөлбөрийн чанарыг а. хичээлийн агуулга, сэдвийн уялдаатай эсэх, б. хичээлийн даалгавар үр дүнтэй эсэх, в. бие даалтын даалгавар оюутныг сорьсон эсэх, г. үнэлгээний тест чанартай эсэх, д. хичээлийн хөтөлбөрт сэтгэл хангалуун эсэх гэсэн шалгуураар судалж үзсэний үр дүнг дараах графикаар үзүүллээ.




Дээрх графикаас харахад бүх шалгуурууд ерөнхийдөө ижил үнэлгээтэй байгаа ба төгсөгчид хөтөлбөрийн чанарт сэтгэл хангалуун байдаг гэж үнэлсэн байна.

Харин дадлагын чанар ямар байсныг а. багшлах дадлагын бодлого, удирдамж, зорилго, үйл ажиллагаа ойлгомжтой байсан эсэх, б. дадлагын багш тохирсон зөвлөгөөг өгч чадаж байсан эсэх, в. дадлагын үеэр багш сайн дэмжин тусалж байсан эсэх, г. дадлагын үеэр талуудын 3 талын хамтын ажиллагаа сайн байсан эсэх, д. дадлагаар багшлах арга барилд суралцаж чадсан эсэх, е. дадлагадаа сэтгэл хангалуун байсан эсэх гэсэн 6 шалгуураар судалж үзэхэд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн 48.8% нь дадлагын үеэр багшлах арга барилд суралцаж чадаж байсан, 41.9% нь дадлагын багш оюутанд тохирсон зөвлөгөөг өгч байсан гэж үнэлжээ. Харин 16.3% нь дадлагын үеийн багшийн дэмжлэг, 3 талын хамтын ажиллагаа муу байсан гэжээ.




Оюутанд зөвлөх ажилтны мэдлэг, чадвар, хандлагыг а. мэдлэг, чадвар, б. харилцаа, хандлага, ёс суртахуун, в. төгсөгчийн сэтгэл ханамжаар үнэлж үзэхэд оюутанд туслах ажилтны мэдлэг чадвар хандлагыг 48.8% нь сайн гэж үнэлсэн байна.




**с) Сургалтын орчин**

Сургалтын орчин, сургуулийн дэмжлэгийг а. техник технологийн хүртээмжтэй байдал, б. оюутны амрах, хооллох орчны тав тух хангагдсан байдал, в. сургалтын орчны ая тух, суралцах таатай орчин бүрдсэн байдал, г. оюутнаа дэмжих тогтолцоо бүрдсэн байдал (эрдмийн ажлын болон санхүүгийн дэмжлэг), д. номын сангийн нөхцөл байдал (уншиж судлах материал, интернэт орчин, тав тух, үйлчилгээний чанар) гэсэн 5 шалгуураар үнэлэхэд сургалтын орчны ая тухтай байдал болон оюутнаа дэмжих тогтолцоо хамгийн өндөр буюу 34.9%-39.5% байгаа бол номын сангийн үйлчилгээ болон техник технологийн хүртээмжтэй байдлыг сайжруулах шаардлагатай үр дүн харагдаж байна.




**д) Багшлах боловсон хүчин**


Харин багшлах боловсон хүчний мэргэшсэн байдлыг а. заадаг хичээлийн мэдлэг, б. багшлах ур чадвар, в. багшийн ерөнхий мэдлэг, чадвар гэсэн 3 шалгуураар судлахад багшлах ур чадварын хувьд багш нарыгаа мэргэшсэн гэж үнэлсэн байна.



Багш нарын академик чадварыг а. эрдэм шинжилгээний ажилд маань оновчтой зөвлөгөөг өгч чадсан эсэх, б. Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар сайн байсан эсэх, в. судалгааны ажилд дэмжиж чадсан эсэх, г. багш нарын эрдэм шинжилгээний мэдлэг чадварт сэтгэл хангалуун байсан эсэх гэсэн 4 шалгуураар судалж үзэхэд 53.5% нь оюутны судалгааны ажлыг дэмжиж байсан гэж үнэлсэн бол 41.9% нь эрдэм шинжилгээний оновчтой зөвлөгөөг зарим талаар өгч байгаагүй гэсэн үр дүн харагдаж байна.



Багшийн хандлага, ёс суртахууныг а. суралцагчдын ялгаатай байдал мэдрэмжтэй ханддаг эсэх, б. суралцагчдын хэрэгцээнд хариуцлагатай ханддаг эсэх, в. суралцагч төвтэй арга барилтай эсэх, г. багш-оюутны харилцааг эрхэмлэдэг гэдгээ харуулдаг эсэх, д. багшийн үнэлгээ шударга, бодитой эсэх гэсэн 5 шалгуураар үнэлэхэд судалгаанд хамрагдсан төгсөгчдийн талаас илүү хувь нь багшийн оюутанд хандах хандлага, харилцаа, ёс суртахууныг эергээр үнэлсэн бол суралцагчдын ялгаатай байдалд хандах мэдрэмжийг 29.5% нь сул гэж үнэлсэн байна.



### 3. Оюутан суралцагчид

#### а) Ерөнхий мэдээлэл

Магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэх хөтөлбөрийн үнэлгээний судалгаанд одоо суралцаж буй 50 оюутан хамрагдсанаас 4 курсийн оюутан 74%, 2 курсийн оюутан 22%, 3 курсийн оюутан 4% эзэлж байна. Тэдний 80% нь эзэмшиж буй мэргэжилдээ сэтгэл хангалуун байгаа ч 60% нь өнөөгийн багш мэргэжлийн нэр хүндийг дунд зэрэг гэж үнэлжээ.

#### б) Хөтөлбөрийн чанар

Оюутнуудад хөтөлбөрийн бодлого хэр нээлттэй, ойлгомжтой байсныг төгсөгчдийн нэгэн адил а. элсэлтийн бодлого, б. үнэлгээний бодлого, в. сургалтын бодлого, г. хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх бодлого гэсэн шалгуураар судалж үзэхэд




судалгаанд оролцогчдын 50% - 60% нь элсэлтийн, үнэлгээний, сургалтын бодлогыг тодорхой, 34% нь л хөгжлийн бэрхшээлтэй оюутанд үйлчлэх бодлогыг тодорхой, 28% нь тодорхойгүй гэж үнэлсэн байна.

Хичээлийн хөтөлбөрийн чанарыг мөн а. хичээлийн агуулга, сэдвийн уялдаатай эсэх, б. хичээлийн даалгавар үр дүнтэй эсэх, в. бие даалтын даалгавар оюутныг сорьсон эсэх, г. үнэлгээний тест чанартай эсэх, д. хичээлийн хөтөлбөрт сэтгэл хангалуун эсэх гэсэн шалгуураар судалж үзсэний үр дүнг дараах графикаар үзүүлээ.




Дээрх графикаас харахад бүх шалгуурууд ерөнхийдөө 60%-68%-ийн үнэлгээтэй байгаа ч төгсөгчдөөс ялгаатай нь хөтөлбөрийн чанарт сэтгэл хангалуун байгаа оюутны хувь төгсөгчдийнхтэй харьцуулбал буурсан үзүүлэлттэй байна.

Харин дадлагын чанар ямар байгааг мөн адил а. багшлах дадлагын бодлого, удирдамж, зорилго, үйл ажиллагаа ойлгомжтой байсан эсэх, б. дадлагын багш тохирсон зөвлөгөөг өгч чадаж байсан эсэх, в. дадлагын үеэр багш сайн дэмжин тусалж байсан эсэх, г. дадлагын үеэр талуудын 3 талын хамтын ажиллагаа сайн байсан эсэх, д. дадлагаар багшлах арга барилд суралцаж чадсан эсэх, е. дадлагадаа сэтгэл хангалуун байсан эсэх гэсэн 6 шалгуураар судалж үзэхэд судалгаанд хамрагдсан оюутнуудын 68% нь 3 талын хамтын ажиллагаа сайн байсан, 66% нь дадлагын бодлого, удирдамж ойлгомжтой байсан гэж үнэлжээ.



Дадлагын үеэр багшлах ур чадварт суралцсан эсэхийг судалж үзэхэд 70%-аас дээш оюутнууд багш мэргэжлийн үнэ цэнэ, ач холбогдлыг ойлгосон гэж байгаа ч 20% нь суралцах хугацаандаа эзэмшсэн мэдлэг чадвартаа зарим талаар сэтгэл хангалуун биш байгаа үр дүн гарсан байна.




Оюутанд зөвлөх ажилтны мэдлэг, чадвар, хандлагыг а. мэдлэг, чадвар, б. харилцаа, хандлага, ёс суртахуун, в. төгсөгчийн сэтгэл ханамжаар үнэлж үзэхэд судалгаанд хамрагдсан оюутнуудын 62% нь оюутанд туслах ажилтны мэдлэг чадвар хандлагыг нь сайн, сэтгэл ханамжтай байгаагаа илэрхийлжээ.



### с) Сургалтын орчин


Сургалтын орчин, сургуулийн дэмжлэгийг а. техник технологийн хүртээмжтэй байдал, б. оюутны амрах, хооллох орчны тав тух хангагдсан байдал, в. сургалтын орчны ая тух, суралцах таатай орчин бүрдсэн байдал, г. оюутнаа дэмжих тогтолцоо бүрдсэн байдал (эрдмийн ажлын болон санхүүгийн дэмжлэг), д. номын сангийн нөхцөл байдал (уншиж судлах материал, интернэт орчин, тав тух, үйлчилгээний чанар) гэсэн 5 шалгуураар үнэлэхэд номын сангийн үйлчилгээ, орчныг 54% нь сайн гэж үнэлсэн нь төгсөгчдийнхөөс өссөн дүнтэй харагдаж байна. Харин техник технологийн хүртээмж, тав тухтай орчныг

38%-42% нь сул гэж үнэлсэн байна. Ерөнхийдөө сургалтын орчны үнэлгээ төгсөгчдийн судалгаанаас өссөн дүнтэй гарсан байна.



**d) Багшлах боловсон хүчин**


Харин багшлах боловсон хүчний мэргэшсэн байдлыг а. заадаг хичээлийн мэдлэг, б. багшлах ур чадвар, в. багшийн ерөнхий мэдлэг, чадвар гэсэн 3 шалгуураар судлахад оюутнууд багш нарынхаа ур чадварыг мэргэжлийн гэж үнэлсэн хэдий ч 14%-18% нь зарим талаар дутагдалтай гэж үнэлсэн байна.



Багш нарын академик чадварыг мөн адил а. эрдэм шинжилгээний ажилд маань оновчтой зөвлөгөөг өгч чадсан эсэх, б. Судалгааны мэдээлэлд дүн шинжилгээ хийх чадвар сайн байсан эсэх, в. судалгааны ажилд дэмжиж чадсан эсэх, г. багш нарын эрдэм шинжилгээний мэдлэг чадварт сэтгэл хангалуун байсан эсэх гэсэн 4 шалгуураар судалж үзэхэд оюутнуудын 60% нь багш нарын эрдэм шинжилгээний мэдлэг чадвар, дүн



шинжилгээ хийх чадварт сэтгэл хангалуун байгаа бол 30% нь оюутны судалгааны ажлыг дэмжиж буй байдал, оновчтой зөвлөгөө өгөх чадварыг зарим талаар сул гэж үнэлсэн үр дүн харагдаж байна.



Багшийн хандлага, ёс суртахууныг а. суралцагчдын ялгаатай байдал мэдрэмжтэй ханддаг эсэх, б. суралцагчдын хэрэгцээнд хариуцлагатай ханддаг эсэх, в. суралцагч төвтэй арга барилтай эсэх, г. багш-оюутны харилцааг эрхэмлэдэг гэдгээ харуулдаг эсэх, д. багшийн үнэлгээ шударга, бодитой эсэх гэсэн 5 шалгуураар үнэлэхэд судалгаанд хамрагдсан оюутнуудын 60% нь багш нараа оюутнуудынхаа хэрэгцээнд хариуцлагатай ханддаг гэж үнэлсэн хэдий ч гурван оюутан тутмын нэг нь багшийн харилцаа, ёс суртахуунд сэтгэл дундуур явдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Ялангуяа оюутны ялгаатай байдалд мэдрэмжтэй хандах байдлыг хамгийн сул буюу 14% нь муу гэж үнэлсэн нь анхаарал татаж байна. Энэ нь төгсөгчдийн судалгааны үр дүнтэй ч нийцэж байна.



## **Хязгаарлагдмал байдал**

Багш, оюутан, төгсөгчдийн судалгаанд оролцох идэвх ерөнхийдөө сул байсан нь судалгааны үр дүнгийн бодит байдлыг хязгаарлаж байна.

## **ДҮГНЭЛТ**

Дээрх судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Багш мэргэжлийн хөтөлбөрийн чанар, хичээлүүдийн уялдаа холбоо, агуулгын шинэлэг байдал зэрэг нь хангалттай гэж үнэлж байгаа ч үнэлгээний хэлбэрийг нэмэгдүүлэх, илүү бодитой, бүтээлээр үнэлж байхыг санал болгосон нь үнэлгээ болон хөтөлбөрийн сайжруулалтыг сайжруулах хэрэгтэй байгаа нь харагдаж байна. Хөтөлбөрийн чанар дээр Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад ээлтэй бодлого дутагдаж байгааг төгсөгч болон оюутны аль алины нь судалгааны дүн харууллаа. Мөн оюутны хувийн онцлог, хэрэгцээг харгалзах байдал дутагдалтай байгаа нь илэрч байна.
- Сургалтын орчин дээр интернэт орчин, тоног төхөөрөмжийн хүрэлцээ багш, оюутан, төгсөгчдийн аль алиных нь судалгаан дээр анхаарал татаж байна. Номын сангийн үйлчилгээ төгсөгчдийн судалгаанаас оюутны судалгаан дээр ахисан үзүүлэлттэй байгаа нь номын сангийн үйлчилгээний чанар сайжирч байгааг баталж байна.
- Багшлах боловсон хүчин дээр мэргэжлийн багш нар арга зүйн хичээл дээр дутагдалтай байгаа, багшийн ачаалал, ажлын байран дээрээ хөгжих тал дээр анхаарал хандуулах хэрэгтэй байгааг судалгааны үр дүн харуулж байна. Багш мэргэжлээр суралцаж байгаа болон төгсөгчдийн аль аль нь эзэмшсэн мэргэжил, төгссөн сургуульдаа сэтгэл хангалуун байгаа хэдий ч өнөөгийн багшийн нэр хүндэд сэтгэл дундуур явдаг нь харагдлаа.

## **Зөвлөмж**

- Хөтөлбөрийн бодлогыг багш, оюутан, ажил олгогчдод нээлттэй, хүртээмжтэй болгох
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх, сайжруулах үр дүнтэй аргыг сонгон нэвтрүүлэх
- 100 хувь мэргэжлийн багштай болох
- Багшийн тэгш хамруулах боловсролын талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх,
- Сургалтын орчны ая тухтай, оюутанд ээлтэй байдлыг нэмэгдүүлэх, интернэт техник тоног төхөөрөмжийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- Багш мэргэжлийн нэр хүндийг нэмэгдүүлэхэд хувь нэмрээ оруулах

### 3.5. Нэгдсэн үнэлгээний сорил, үр дүн, дүгнэлт

#### СОРИЛЫН ЗОРИЛГО:

- Магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрийн “хүрэх үр дүн”-тэй багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага хэрхэн нийцэж байгааг тодорхойлох

#### ЗОРИЛТ:

- Багш мэргэжилтний үнэт зүйл, итгэл үнэмшил, ёс зүй, харилцааны чадвар
- Багш боловсролын мэдлэг, чадвар
- Багшийн мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлага зэрэгт дүн шинжилгээ хийх

#### СОРИЛ БОЛОВСРУУЛАХАД БАРИМТАЛСАН ЗАРЧИМ:

Бид сорилоо боловсруулах болон сонголт хийхдээ боловсролын зорилтын таксономыг харгалзан дараах мэдлэгийг илрүүлэхэд анхаарлаа хандуулсан. Үүнд:

- Баримтын
- Концепцын буюу ухагдахууны
- Үйлийн
- Метакогнитив

Шалгалт, үнэлгээний даалгавар нь суралцагчийн тухайн хичээлийн хөтөлбөрийн агуулгын хүрээнд мэдлэг эзэмшилтийн түвшнийг үнэлдэг. Тухайлбал, явцын үнэлгээ нь танин мэдэхүйн энгийн түвшний даалгавартай байсан бол эцсийн үнэлгээний даалгавар нь ахисан түвшнийх байна.<sup>1</sup> Даалгавраа боловсруулахдаа хөтөлбөрийн сургалтын зорилт, багш мэргэжилтний үнэт зүйл, итгэл үнэмшил, ёс зүй, харилцааны чадвар, багш боловсролын мэдлэг, чадвар болон багшийн мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлагыг харгалзан боловсруулахыг хичээсэн болно.

#### СОРИЛ АВАХ АРГА, АРГАЧЛАЛ:

Сорилыг авахдаа туршилт, сорилын найдварын зэргийг тогтоосны үндсэн дээр багш боловсролын хөтөлбөрүүдийн нийтлэг зорилго, зорилт, хүрэх үр дүнг судлан харьцуулж, сорилыг боловсруулсан. Сорил нь нийт 50 сонгох даалгавартай бөгөөд багш хөтөлбөрийн Сургалтын онол аргазүй, Багшлахуй суралцахуй болон Боловсролын сэтгэл судлал хичээлийн ерөнхий агуулгын хүрээнд боловсруулсан. Мөн тус сорилыг цахим хэлбэрээр буюу “Google form”-р 2 үе шаттайгаар авсан болно.

#### 1-р үе шат: 2022 оны 03 сарын 26-28 өдөр

Тестийн тохирц гэдэг нь тестийн шалгуур (суралцагч шалгалтын материалыг мэдэж байна уу? эсвэл үгүй юу?) хэр зэрэг үндэслэлтэй, оновчтой байгааг илэрхийлдэг. Тест тохирцтой байх эсэх нь анхаарал хандуулдаг психометрик үзүүлэлт бөгөөд тестийн тохирцтой байдлыг тооцдог стандарт арга нь хүч хөдөлмөр цаг хугацаа их шаарддаг. Тиймээс найдвартай байдлын шинжилгээг тест тохирцын анхан шатны шалгуур гэж ихэвчлэн үздэг.<sup>2</sup> Энэхүү сорилд Монгол Улсын Боловсролын Их сургуулийн багш хөтөлбөрөөр суралцаж буй нийт 44 оюутан хамрагдсан бөгөөд тус сорилын тохирцыг

<sup>1</sup> Ганбат.Л нар. Боловсролын үнэлгээ. УБ. 2017. Хуудас 23

<sup>2</sup> Ганбат.Л нар. Боловсролын үнэлгээ. УБ. 2017. Хуудас 62

тодорхойлох зорилготой болно. Сорил нь нийт 50 сонгох даалгавар бүхий багш хөтөлбөрийн Сургалтын онол аргазүй, Багшлахуй суралцахуй болон Боловсролын сэтгэл судлал хичээлийн ерөнхий агуулгын хүрээнд боловсруулсан ба оюутны авсан хамгийн өндөр болон хамгийн бага онооны нийлбэр бүхий тус бүр 5 даалгаврыг шинэчлэн сайжруулсан.

## **2-р үе шат: 2022 оны 04 сарын 07-24 өдөр**

Энэхүү сорилд магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрөөр суралцаж буй нийт 197 оюутан хамрагдсан. Сорилын үндсэн зорилго нь магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрийн “хүрэх үр дүн”-тэй төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага нийцэж байгааг тодорхойлоход чиглэгдсэн. Сорил нь нийт 50 сонгох даалгавар бүхий багш хөтөлбөрийн Сургалтын онол аргазүй, Багшлахуй суралцахуй болон Боловсролын сэтгэл судлал хичээлийн ерөнхий агуулгын хүрээнд боловсруулсан ба ирүүлсэн нийт сорилоос шаардлага хангасан 146 сорилын үр дүнг боловсруулалтад оруулсан.

## **Мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийсэн арга, аргачлал**

Сорилыг боловсруулахдаа магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрийн хүрэх үр дүнг харьцуулан судалж нийтлэг байгаа дараах үр дүнд дүйцүүлэн боловсруулсан. Ингэхдээ хувь хүний мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлон үнэлэх даалгавар оруулаагүй болно.

### **Үүнд: РЕО /Хөтөлбөрийн сургалтын зорилтууд/**

1. Өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх, шинийг эрэлхийлэх, бие даан бүтээлчээр сэтгэх, системтэйгээр төлөвлөх, судлан шинжлэх арга зүй, аргачлал, аргыг мэддэг, үйл ажиллагаандаа хэрэглэдэг, асуудал шийдвэрлэх чадвартай
2. Багаар ажиллах, харилцах, хамтран суралцах чадвартай, нийгмийн амьдрал, нийгмийн байгууллын зүй тогтол, хүний эрх, эрх чөлөө, үнэт зүйлс, эрүүл аж төрөх ёс мэддэг, хүндэтгэдэг
3. Суралцагч бүрийн хөгжил, төлөвшлийн онцлогийг судалдаг, ялгаатай байдалд нь хүндэтгэлтэй ханддаг, тэдний ахиц амжилт, хөгжлийг дэмждэг
4. Суралцагчийн сурч танин мэдэх зүй тогтолд тулгуурлан сурах, сургах үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй, цаг үеийн мэдрэмжтэй зохион байгуулж, түүний хэрэгжилтэд үнэлгээ хийн байнга сайжруулдаг
5. Боловсролыг өргөн утгаар нь ойлгож, багш мэргэжил, багшийн ажил, үүргийг ухамсарласан, багшийн мэргэжлийн стандарт, ажлын байрны шаардлага хангах чадамжтай болсон байна.
6. Байгаль- хүн- нийгэм хүрээлэн буй орчны цогц тогтолцооны зүй тогтол, бодит хуулиудын үйлчлэлийг танин мэдэж аливаа үзэгдэл харилцаанд үнэлэлт дүгнэлт өгч хүмүүст итгэл үнэмшил төрүүлэх
7. Багшийг суралцагчдын өсөн нэмэгдэж буй сурах хэрэгцээг хангаж, сурах үйлийг чадваржуулах мэдлэг, туршлага, арга барилтай, мэргэжлийн хөгжлийг хангахуйц насан турш суралцах чадвартай сайн багш болгон төлөвшүүлэх
8. Багш нар мэддэг, эсвэл сурсан зүйлийнхээ талаар эргэцүүлэн цаашид ямар мэдлэг, чадвар олж авах хэрэгцээ, шаардлага байгаагаа тодорхойлох, шинэ технологийг туршин хэрэгжүүлэх, туршлага хуримтлуулах, ингэснээр сурган хүмүүжүүлэх практик үйл ажиллагааг шинэчлэх, хөгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх

### **Багш мэргэжилтний үнэт зүйл, итгэл үнэмшил, ёс зүй, харилцааны чадвар**

1. Суралцагчийн онцлог, ялгаатай байдлыг мэдэх, тодорхойлох, ойлгох, хүндэтгэлтэй хандах
2. Хүүхэд бүрд амжилттай сурч чадна гэдэг итгэл өгөх, тэднийг чадавхаа бүрэн дайчилж хөгжихөд нь хөтлөх, туслах
3. Хүүхдийн хөгжил төлөвшилд цогц хандах, тэдний амжилт, ахиц дэвшлийг урамшуулах, үнэлэх
4. Бусдыг дэмжих, хамтран ажиллагсдын үүрэг, хувь нэмрийг үнэлэх, илэрхийлэх
5. Багшлах ажилдаа чин сэтгэлээсээ ажил хэрэгч, хариуцлагатай, тууштай хандах итгэл үнэмшил бий болгох

### **Багш боловсролын мэдлэг, чадвар**

1. Суралцагчдын танин мэдэхүйн хөгжлийн зүй тогтлыг таньж мэдэх, сургалтад харгалзах мэдлэг, чадвар
2. Боловсролын онол, үзэл баримтлал, бодлого, эрх зүй, стандарт тэдгээрийн хэрэгжилт
3. Суралцахуйн зүй тогтол, сургалтыг зохион байгуулахад харгалзах
4. Сургалтын төлөвлөлт, сургалтын аргууд, сонголт, тэдгээрийн хэрэглээ
5. Хүүхэд/ суралцагч бүрийн онцлогт тохирсон сургалтын аргуудыг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх мэдлэг, чадвар

### **Багшийн мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлага**

1. Академик мэдлэг, чадвар, хандлага
2. Мэргэшиж буй шинжлэх ухааны салбарын мэдлэг, чадвар
3. Бусдын ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, жэндерийн мэдрэмжтэйгээр аливаад хандах,
4. Суралцаж буй багш мэргэжлийнхээ хөгжлийн хандлагыг мэдэрдэг, мэргэжилдээ сонирхолтой, чадвараа байнга дээшлүүлэх,
5. Суралцаж буй багш мэргэжлийнхээ хөгжлийн хандлагыг мэдэрдэг, мэргэжилдээ сонирхолтой, чадвараа байнга дээшлүүлэх.

### ***БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ХИЧЭЭЛЭЭР АВАХ СОРИЛЫН БОЛОВСРУУЛАЛТ, НАЙДВАРЫН ЗЭРЭГ ТОГТООСОН БАЙДАЛ***

#### **2-р үе шат: 2022 оны 04 сарын 07-24 өдөр**

Тус сорилд магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрөөр суралцаж буй нийт 146 оюутан хамрагдсан. Сорилын үндсэн зорилго нь магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага нийцэж байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгдлээ. Сорил нь нийт 50 сонгох даалгавар бүхий багш хөтөлбөрийн Сургалтын онол аргазүй, Багшлахуй суралцахуй болон Боловсролын сэтгэл судлал хичээлийн ерөнхий агуулгын хүрээнд боловсруулсан ба ирүүлсэн нийт сорилоос шаардлага хангасан 146 сорилын үр дүнг боловсруулалтад оруулсан.

Тестийн агуулга хэр зэрэг төстэй байхаас шалтгаалахгүй бөгөөд бодит байдалд нэг тестийг нэг ангийн суралцагчдаас хоёр өдөр дараалан авахад гарах үр дүн өөр байх нь түгээмэл байдаг. Харин нэг ижил материалаар бэлтгэсэн хоёр тестээр шалгахад шалгуулагчийн авах оноо адил байхыг илүүд үзэх нь мэдээж. Өөрөөр хэлбэл, шалгуулагчийн тестэд авсан оноо хоорондоо хэр зэрэг ойролцоо байна тест төдий чинээ

найдвартай байна гэсэн үг.<sup>3</sup>

Тестийн чанарыг найдвар болон тохирц гэсэн хоёр шалгуураар тодорхойлдог. Тестийн найдвартай байдал гэдэг нь тухайн тест, даалгаврыг шалгуулагчдаас өөр өөр цаг хугацаа, нөхцөлд авахад үр дүн нь ойролцоо байх хэмжигдэхүүн юм.

Өөрөөр хэлбэл, ижил шинж чанарыг хэмжих зорилгоор боловсруулсан. Даалгаврыг тухайн тестэд орж буй даалгавар хэр зэрэг хамааралтай болохыг илэрхийлэх корреляцийн коэффициентээр тодорхойлогдоно. Найдвартай байдлын түвшнийг дараах байдлаар ангилдаг байна.

*Хүснэгт 1. Найдвартай байдлын түвшин*

Авах утга	Түвшин
$r \geq 0.9$	Маш <u>сайн</u>
$0.9 > r \geq 0.8$	Сайн
$0.8 > r \geq 0.7$	Зөвшөөрөгдөхүйц/дундаж
$0.7 > r \geq 0.6$	Тааруухан
$0.6 > r \geq 0.5$	Тохиромжгүй
$r < 0.5$	Үл зөвшөөрөгдөхүйц/маш муу

$$r = \frac{n(\sum xy) - (\sum x)(\sum y)}{\sqrt{[n\sum x^2 - (\sum x)^2][n\sum y^2 - (\sum y)^2]}}$$

*Хүснэгт 1.1 Найдвартай байдлын коэффициент*

Сондгой дугаартай даалгаварт авсан оноо буюу x	Тэгш дугаартай даалгаварт авсан оноо буюу y	x*x	y*y	x*y
<b>2903</b>	<b>2825</b>	<b>67005</b>	<b>63309</b>	<b>64116</b>

Найдвартай байдлыг тодорхойлох олон арга байдаг. Эдгээрээс нэг ижил шинж чанарын хоёр тест даалгаврын хувьд хэр зэрэг хамааралтай байгааг хэмжих зорилгоор тооцоолол хийдэг Пирсоны корреляцийн коэффициентийг тооцоолон үзвэл 9.36 байна.

### **БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ХИЧЭЭЛЭЭР АВАХ СОРИЛЫН НАЙДВАРЫН ЗЭРЭГ ТОГТООСОН БАЙДАЛ**

Бид сорилыг агуулгыг боловсруулахдаа магадлан итгэмжлэгдсэн багш боловсролын нийт 13 хөтөлбөрийн хүрэх үр дүн болон сургалтын зорилго, зорилтуудыг харьцуулан судалж, агуулгын давхцалыг харгалзан тооцоолон гаргасан болно. Энэхүү ажлын үр дүнд дараах 10 агуулга бүхий хөтөлбөрийн зорилго, зорилтыг багцлан гаргасан. Сорил нь магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрийн хүрэх үр дүн, багш хөтөлбөрөөр төгсөгчдийн мэдлэг, чадвар, хандлага ямар түвшинд нийцэж байгааг тодорхойлоход чиглэгдсэн. Хөтөлбөрүүдийн зорилго, зорилтыг дараах байдлаар багцлан авч үзсэн. Үүнд:

<sup>3</sup> Ганбат.Л нар. Боловсролын үнэлгээ. УБ. 2017. Хуудас 59

1. Суралцагч бүрийн хөгжил, төлөвшлийн онцлогийг судлах
2. Суралцагчийн ахиц амжилт, хөгжлийг дэмжих
3. Сургалтын үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах
4. Судалгаа шинжилгээ хийх, үр дүнг боловсруулах
5. Сургалтын явцад тохиолддог түгээмэл асуудлыг шийдвэрлэх
6. Багаар ажиллах, харилцах, хамтран суралцах
7. Хүний эрх, эрх чөлөө, үнэт зүйлсийг хүндэтгэх
8. Багш боловсролыг өргөн утгаар нь ойлгож, үүргээ ухамсарлах
9. Багшийн мэргэжлийн стандарт, ажлын байрны шаардлага хангах
10. Эзэмшсэн мэргэжилдээ чин сэтгэлээсээ хандах зэрэг байна.

Сорилд оролцож буй оюутан дээрх агуулга тус бүрд харгалзах дунджаар 5 даалгавар гүйцэтгэхээр төлөвлөсөн болно. Тус сорилд магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрөөр суралцаж буй нийт 197 оюутан хамрагдсан. Сорил нь нийт 50 сонгох даалгавар бүхий багш хөтөлбөрийн Сургалтын онол аргагүй, Суралцахуй ба багшлахуйн үндэс болон Боловсролын сэтгэл судлал хичээлийн ерөнхий агуулгын хүрээнд боловсруулсан ба ирүүлсэн нийт сорилоос шаардлага хангасан 146 сорилын үр дүнг боловсруулалтад оруулсан. Энэхүү сорил нь мэргэжлийн тэнхимээс орох хичээлийн зорилтууд, хүрэх үр дүнг тооцоогүй болно. Хичээл тус бүрийн агуулгад хамаарагдах даалгаврын тооны харьцаа:

- Сургалтын онол арга зүй 20
- Суралцахуй ба багшлахуй 20
- Боловсролын сэтгэл судлал 10

Сорилын найдвартай байдлыг тодорхойлохдоо: Нэг ижил шинж чанарын хоёр даалгаврын хувьд хэр зэрэг хамааралтай байгааг хэмжих зорилгоор тооцоолол хийдэг Пирсоны корреляцийн коэффициентийг тооцоолон гаргасан. Дээрх сорилын найдвартай байдлын коэффициент нь 9,36 байгаа нь найдварын зэрэг өндөр байгааг харуулж байна.

### ***БОЛОВСРОЛ СУДЛАЛЫН ХИЧЭЭЛЭЭР АВАХ СОРИЛЫН ЯВЦ ҮР ДҮН***

Бид сорилын найдварын зэргийг тодорхойлсны үндсэн дээр магадлан итгэмжлэгдсэн багш хөтөлбөрөөр суралцаж буй нийт 197 оюутан хамрагдсан. Хөтөлбөрүүдийн зорилго, зорилтыг хэрэгжилтийг багцлан авч үзвэл:



Хүснэгт 2. Суралцагчийн суралцах чадамжийг хөгжүүлэх арга зүйн талаар эзэмшсэн мэдлэгийн түвшин

Суралцагчийн суралцах чадамжийг хөгжүүлэх арга зүй		Зөв	Хувь	Буруу	Хувь	Гүйцэтгэл %
1	30	10	42	14	58	100
2	31	12	50	12	50	100
3	32	11	46	13	54	100
4	33	15	63	9	37	100
5	40	11	46	13	54	100
Дундаж		<b>11</b>	<b>49</b>	<b>12</b>	<b>51</b>	<b>100</b>

Сорил өгсөн оюутны 51 хувь нь суралцагчийн суралцах чадамжийг хөгжүүлэх арга зүйн талаарх даалгаврыг буруу гүйцэтгэсэн байна. Иймд боловсролын сэтгэл судлал болон суралцахуй багшлахуй хичээлийн хөтөлбөрийн агуулгад дүн шинжилгээ хийх, хэрэгжилтэд хяналт тавих шаардлагатай байна. Мөн суралцагч бүрийн хөгжил, төлөвшлийн онцлогийг судалдаг, ялгаатай байдалд нь хүндэтгэлтэй ханддаг, тэдний ахиц амжилт, хөгжлийг дэмждэг байх хөтөлбөрийн сургалтын зорилтын хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөх магадлалтай байна.

Хүснэгт 3. Суралцагчийн сэтгэхүйн үйлдэл, түүнийг хөгжүүлэх арга зүйн талаар эзэмшсэн мэдлэгийн түвшин

Сэтгэхүйн үйлдэл хөгжүүлэлт		Зөв	Хувь	Буруу	Хувь	Гүйцэтгэл %
1	27	12	50	12	50	100
2	29	10	42	14	58	100
3	35	3	13	21	88	100



4	36	10	42	14	58	100
5	37	8	33	16	67	100
Дундаж		<b>9</b>	<b>36</b>	<b>15</b>	<b>64</b>	<b>100</b>

Суралцагчийн онцлог, ялгаатай байдлыг мэдэх, тодорхойлох, ойлгох, хүндэтгэлтэй хандах болон хүүхэд бүрд амжилттай сурч чадна гэдэг итгэл өгөх, тэднийг чадавхаа бүрэн дайчилж хөгжихөд нь хөтлөх, туслах хөтөлбөрийн сургалтын зорилтуудад хамаарагдах агуулгын мэдлэгийг шалгасан сорилын 64%-ийг зөв гүйцэтгэсэн байна.

*Хүснэгт 4. Сэтгэл судлалын онол, зарчмын талаар эзэмшсэн мэдлэгийн түвшин*

Сэтгэл судлалын онол, зарчим		Зөв	Хувь	Буруу	Хувь	Гүйцэтгэл %
1	26	7	29	17	71	100
2	28	10	42	14	58	100
3	34	10	42	14	58	100
4	38	6	25	18	75	100
5	39	14	58	10	42	100
Дундаж		<b>9</b>	<b>39</b>	<b>15</b>	<b>61</b>	<b>100</b>

Суралцагчдын танин мэдэхүйн болон сэтгэхүйн онцлог, ялгаатай байдал, зүй тогтлыг таньж мэдэх түүнийг сургалтад харгалзах мэдлэгийг илрүүлэх багц даалгаврыг оролцогчдын 61 хувь нь гүйцэтгэж чадаагүй байна. үүнээс харахад суралцагчийн онцлог, ялгаатай байдлыг мэдэх, тодорхойлох, ойлгох хөтөлбөрийн зорилтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Боловсрол, боловсролын түвшин		Зөв	Хувь	Буруу	Хувь	Гүйцэтгэл %
1	1	129	58	92	42	100
2	3	93	42	128	58	100
3	7	154	70	67	30	100
4	8	149	67	72	33	100
5	9	155	70	66	30	100
Дундаж		<b>136</b>	<b>62</b>	<b>85</b>	<b>38</b>	<b>100</b>

Багшийг суралцагчдын өсөн нэмэгдэж буй сурах хэрэгцээг хангаж, сурах үйлийг чадваржуулах мэдлэг, туршлага, арга барилтай, мэргэжлийн хөгжлийг хангахуйц насан турш суралцах чадвартай сайн багш болгон төлөвшүүлэх хийгээд суралцаж буй багш мэргэжлийнхээ хөгжлийн хандлагыг мэдэрдэг, мэргэжилдээ сонирхолтой, чадвараа байнга дээшлүүлэх хөтөлбөрийн сургалтын зорилтуудад хамаарагдах агуулгын мэдлэгийг шалгасан даалгаврын 62%-ийг зөв гүйцэтгэсэн байна.

<b>Боловсролын үйлчилгээ, хүртээмж чанар</b>		<b>Зөв</b>	<b>Хувь</b>	<b>Буруу</b>	<b>Хувь</b>	<b>Гүйцэтгэл %</b>
1	12	146	66	75	34	100
2	13	125	57	96	43	100
Дундаж		<b>136</b>	<b>61</b>	<b>86</b>	<b>39</b>	<b>100</b>

Боловсролыг өргөн утгаар нь ойлгож, багш мэргэжил, багшийн ажил, үүргийг ухамсарласан, багшийн мэргэжлийн стандарт, ажлын байрны шаардлага хангах чадамжтай болсон байх хөтөлбөрийн сургалтын зорилтуудад хамаарагдах агуулгын мэдлэгийг шалгасан даалгаврын 61%-ийг зөв гүйцэтгэсэн байна.

<b>Сургалт төлөвлөлт</b>		<b>Зөв</b>	<b>Хувь</b>	<b>Буруу</b>	<b>Хувь</b>	<b>Гүйцэтгэл %</b>
1	2	126	57	95	43	100
2	10	129	58	92	42	100
3	6	112	51	109	49	100
4	11	155	70	66	30	100
Дундаж		<b>131</b>	<b>59</b>	<b>91</b>	<b>41</b>	<b>100</b>

Суралцахуйн зүй тогтлыг сургалтыг зохион байгуулахад харгалзах хөтөлбөрийн сургалтын зорилтуудад хамаарагдах агуулгын мэдлэгийг шалгасан даалгаврын 59%-ийг зөв гүйцэтгэсэн байна. Дээрх багц сорилын даалгавар нь сургалт зохион байгуулах талаар мэдлэгийн түвшинг илрүүлэх зорилготой бөгөөд багшлах болон туршин заах дадлага хийсэн оюутнуудын хувьд хангалтгүй хариулсан байна.

<b>Боловсрол, сургалтын үзэл санаа, шинэчлэл</b>		<b>Зөв</b>	<b>Хувь</b>	<b>Буруу</b>	<b>Хувь</b>	<b>Гүйцэтгэл %</b>
1	4	138	62	83	38	100
2	5	135	61	86	39	100
3	16	135	61	86	39	100
4	23	119	54	102	46	100
Дундаж		<b>132</b>	<b>60</b>	<b>89</b>	<b>40</b>	<b>100</b>

Өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх, шинийг эрэлхийлэх, бие даан бүтээлчээр сэтгэх, системтэйгээр төлөвлөх, судлан шинжлэх арга зүй, аргачлал, аргыг мэддэг, үйл ажиллагаандаа хэрэглэдэг, асуудал шийдвэрлэх чадвартай эзэмшсэн байх хөтөлбөрийн сургалтын зорилтуудад хамаарагдах агуулгын мэдлэгийг шалгасан даалгаврын 60%-ийг зөв гүйцэтгэсэн байна.

<b>Сургалт, түүний бүтэц, төрөл</b>		<b>Зөв</b>	<b>Хувь</b>	<b>Буруу</b>	<b>Хувь</b>	<b>Гүйцэтгэл %</b>
1	14	156	71	65	29	100

2	17	118	53	103	47	100
3	18	119	54	102	46	100
4	19	155	70	66	30	100
5	20	116	52	105	48	100
6	21	135	61	86	39	100
7	22	130	59	91	41	100
8	24	113	51	108	49	100
9	25	140	63	81	37	100
Дундаж		131	59	90	41	100

Багш нар мэддэг, эсвэл сурсан зүйлийнхээ талаар эргэцүүлэн цаашид ямар мэдлэг, чадвар олж авах хэрэгцээ, шаардлага байгаагаар тодорхойлох, шинэ технологийг туршин хэрэгжүүлэх, туршлага хуримтлуулах, ингэснээр сурган хүмүүжүүлэх практик үйл ажиллагааг шинэчлэх, хөгжүүлэх боломж нөхцөлийг бүрдүүлэх хөтөлбөрийн сургалтын зорилтуудад хамаарагдах агуулгын мэдлэгийг шалгасан даалгаврын 59%-ийг зөв гүйцэтгэсэн байна.

Дээрх сорилын үр дүнгээс харахад багш боловсролын хөтөлбөрөөр төгсөж байгаа төгсөгчид боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулиудын эрэлт хэрэгцээнд нийцсэн сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх мэдлэг чадвар дутмаг байгаа нь харагдаж байна.

Сорилын үр дүнг боловсруулах явцад суралцагчийн онцлог, ялгаатай байдлыг мэдэх, тодорхойлох, ойлгох, хүндэтгэлтэй хандах хүүхэд бүрд амжилттай сурч чадна гэдэг итгэл өгөх, тэднийг чадавхаа бүрэн дайчилж хөгжихөд нь хөтлөх, туслах итгэл үнэмшил хангалтгүй байгаа ажиглагдлаа (*Хүснэгт 2.*). Иймд сурахуй болон сургахуйн агуулгатай холбоотой хичээлийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийж, багш мэргэжлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, багш нарын ур чадварыг сайжруулахад чиглэсэн агуулга, арга зүйн шинэчлэл хийх хэрэгцээтэй байна.

## ДҮГНЭЛТ, САНАЛ

- Ерөнхий боловсролын сургууль дахь тулгамдаж буй асуудал, хэтийн төлөв байдал, хэрэглэгчдийн хэрэгцээ, шаардлагад баримжаалан хөтөлбөрөө сайжруулах шаардлагатай байна. Хөтөлбөрөө боловсруулахдаа хэрэгцээний судалгаанд суурилсан, хичээл бүрээр оюутны хүрэх үр дүнг томъёолж сургалтын хөтөлбөртөө тусгах. /хэрэгжихүйц/ Мөн мэргэжлийн суралцахуйн үр дүнг илүү оновчтой болгох, сургалтын төлөвлөгөөг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.
- Хөтөлбөрийн үр дүнг төлөвлөхдөө агуулгын хувьд практик хэрэглээтэй холбогдож, залгамж холбоотой байхаар боловсруулах. Хөтөлбөр төлөвлөлтийн сургалтын агуулга, арга зүй, үнэлгээний шинэлэг, дэвшилттэй хэлбэрийг тасралтгүй сайжруулах нь зайлшгүй чухал юм.
- Багш боловсролын суурь хичээлүүдийн хүрэх үр дүн хэтэрхий задарсан байгаа тул дахин нягтруулсан сайжруулах шаардлагатай байна.
- Аргазүйн хувьд үр дүнд суурилсан сургалтын арга, технологи, зохион байгуулалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх хэрэгцээтэй байна.

## ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Гадаадад болон дотоодод магадлан итгэмжлэгдсэн багш мэргэжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн судалгааны хүрээнд магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын бүтэц, загварын өөрчлөлттэй уялдуулан, хөтөлбөрийн хэрэгжилтийн ерөнхий арга зүйн удирдамж зааврын дагуу баримт, нотолгооны үндсэн дээр тоон болон чанарын үнэлгээ хийснээр дараах дүгнэлтэд хүрлээ.

1. Олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ASIIN байгууллага ба Монгол улсын БМИҮЗ-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагууд бүтэц агуулгын хувьд ойролцоо боловч нарийвчилсан шалгуурын томъёолол болон магадлан итгэмжлэлийн ач холбогдлын талаар ялгаатай байна. Цаашид хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зорилго, ач холбогдлоос хамаарч шалгуур хэрхэн өөрчлөгдөж болох талаар үргэлжлүүлэн судлах хэрэгцээ байна гэж үзлээ.
2. Улсын хэмжээнд багш боловсон хүчин бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр харьцангуй цөөн байна. Эндээс их, дээд сургуулиудад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр элсэлт авах шаардлага тавьбал олон улсын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлд орох, хөтөлбөрийг чанаржуулах үйл явцад нөлөөлнө гэж үзэж байна.
3. Хөтөлбөрийн агуулгыг бүрдүүлж буй сургалтын төлөвлөгөө дэх хичээлүүдийн хөтөлбөрийн арга зүйд идэвхтэй сургалтын аргуудыг ашигладаг, хичээлд ажиглалт хийж, үр дүнг боловсруулж, оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгаа авдаг давуу тал ажиглагдлаа. Хөтөлбөрийн арга зүйн хэрэгжилтийг хянах, үнэлэх, тогтмол сайжруулах ажлыг төлөвлөгөөтэй зохион байгуулбал сургалтын арга зүйг тасралтгүй хөгжүүлж, хичээлийн чанар дээшилнэ гэж үзэж байна.
4. Хичээлийг иж бүрдэл нь хичээлийн чанар болон хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой байгаа нь харагдсан.
5. Сургалтын төлөвлөгөө дэх хичээлийн CLO-г үнэлэхдээ суралцагчдын ялгаатай байдлыг харгалзсан, шинэлэг, дэвшилттэй хэлбэрийн үнэлгээг боловсруулж, мэргэжлийн суралцахуйн үр дүнг илүү оновчтой болгох хэрэгцээ байна.
6. Хөтөлбөрийн үр дүнг сайжруулахын тулд оролцогч оюутан, багш нар, сонирхогч тал, ажил олгогч, төгсөгч, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний санал, хэрэгцээг судлах судалгааны хүрээг өргөжүүлэн, судалгааны үр дүнг хөтөлбөрийг шинэчлэхэд тусган ажиллах шаардлагатай байна.

# ХАВСРАЛТ

## Хавсралт №1. АЛБАН БИЧИГ



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.ОЧИРХУЯГ ТАНАА

### МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-22-27, Факс: 263727

И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2022.03.09 № 6/1049  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Хүсэлт хүргүүлэх тухай


Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд дотоод болон гадаадад магадлан итгэмжлэгдсэн багш бэлтгэх хөтөлбөрүүдэд хэрэгжилтийн судалгаа хийх, хэрэгжилтийн үнэлгээний шалгуур боловсруулах баг томилогдон ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд танай сургуулийн 1 хөтөлбөр хамрагдаж байна. Иймд магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийн мэдээллийг хавсралтад заасан байдлаар 2022 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор ganbaatar@msue.edu.mn, agiima@msue.edu.mn мэйл хаягаар ирүүлнэ үү.

Мөн 3-4 дүгээр сард хийгдэх хөтөлбөрийн үнэлгээний шалгуурын дагуу хийгдэх хэрэгжилтийн үнэлгээнд холбогдох тэнхим, багш, оюутнаа хамруулж идэвхтэй оролцоно уу.

Дээрх төслийн үр дүнд багш бэлтгэх хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний шалгуур боловсруулагдан гарах бөгөөд танай сургуулийн багш, мэргэжилтнүүдэд зориулсан сургалтаар дамжуулан танилцуулах болно.

Холбоо барих утас: 99788918, 99003812

Хавсралт 2 хуудас

ДЭЭД БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ  
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Х.ТАМИР



14200-1100

..... оны ... сарын ... -ны өдрийн  
... албан бичгийн хавсралт

**Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн хэрэгжилтийн судалгаа хийхэд  
шаардлагатай мэдээлэл**

**Нэг. Ерөнхий мэдээлэл**

Сургууль		Хөтөлбөрийн нэр	
Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн хугацаа		Хөтөлбөрийн индекс	
Магадлан итгэмжлэгдсэн огноо:			

**Хоёр. Хөтөлбөрийн төлөвлөлт**

*а. Хөтөлбөрийн төлөвлөлт ...*

Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага		
Хөтөлбөрийн зорилго (PEO)		
Хөтөлбөрийн зорилт (PLO)		
Нийт хичээлийн үр дүнгийн тоо (CLO)	Хувь хүний мэдлэг, чадвар, хандлага	
	Багш боловсролын мэдлэг, чадвар, хандлага	
	Академик мэдлэг, чадвар, хандлага	



б. Хөтөлбөр боловсруулахдаа ижил хөтөлбөр хэрэгжүүлдэг гадаад дотоодын их дээд сургуулийн хөтөлбөртэй харьцуулсан байдал.

	Сургуулийн нэр	Хөтөлбөрийн нэр	Ямар байдлаар ашигласан
Гадаад			
Дотоод			

**Гурав. Сургалтын төлөвлөгөөний бүтэц**

Бүтэц	Хичээлийн тоо		Нийт кредит	
	Заавал судлах	Сонгон судлах	Заавал судлах	Сонгон судлах
Ерөнхий суурь				
Багш боловсрол				
Мэргэжил (мэргэшил)				
Багш мэргэжлийн дадлага				

**Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.** (Хөтөлбөр боловсруулах хэлэлцэх, баталгаажуулах хэрэгжүүлэх, үнэлэх сайжруулах үйл явцын зураглалыг оруулна уу.)

*Хөтөлбөрөөр суралцагчийн тоо*

Анги Хэлбэр	I	II	III	IV	Нийт	Үүнээс
Өдөр						
Эчнээ						
Хөрвөх						

*Хөтөлбөрт хичээл заадаг багшийн тоо*

№	Төрөл	Үндсэн багшийн тоо	Үүнээс эмэгтэй	Үүнээс Ph.D	Гэрээт багшийн тоо	Үүнээс эмэгтэй	Үүнээс Ph.D
1	Ерөнхий суурь хичээл						
2	Багш боловсролын хичээл						
3	Мэргэжлийн хичээл						

**Тав. Оюутны хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа**

№	Үйл ажиллагааны нэр	Зорилго	Зохион байгуулах нэгж	Хамрах хүрээ	Давтамж
1					
2					


**Зургаа. Багшлах дадлагын удирдлага, зохион байгуулалт.**

*а. Дадлагын ерөнхий мэдээлэл*

№	Дадлагын нэр	Кредит	Үргэлжлэх хугацаа (долоо хоног)	Хамтран ажилладаг байгууллагын тоо
1				
2				
3				



*б. Багш мэргэжлийн дадлагын зохион байгуулалтын зураглал.*



